

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-33

---

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлнэ/	6-20
2.Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх	20-32
3.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэх	хойшлуулав
4.“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх элтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/	32-33

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 12 дугаар сарын 19-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 58 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, Б.Жавхлан;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Ц.Даваасүрэн, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ч.Ундррам нар оролцов.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хэлэлцэх асуудлын 4 дүгээрт хэлэлцэхээр тогтов.

**Нэг.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нарын 7 гишүүн 2023.03.16-ны өдөр Органик бүтээгдэхүүний тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд хүргүүлнэ/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, мөн яамны Татварын бодлогын газрын зөвлөх Т.Энхжаргал, мэргэжилтэн Ч.Мөнхшүр, “Органик хөгжил” төрийн бус байгууллагын гишүүн Л.Энхтуяа, “Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл” төрийн бус байгууллагын тэргүүн, судлаач Г.Алтанхуяг, Монгол Улсын Их сургуулийн Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш, профессор Н.Отгонсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, С.Ганбаатар, С.Одонтуяа, Ц.Сандаг-Очир, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав баглаа боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч Д.Тунгалаг, Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, мөн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Ч.Мөнхшүр нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нар үг хэлэв.

Хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдээ татаж авав./14:55/

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 57 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, мөн газрын ахлах аудитор Х.Энх-Амгалан, аудитын менежер Б.Батчимэг, аудитор О.Дашхонгор, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, Зээлийн батлан даалтын сангийн Төсөл, бизнес хөгжлийн газрын дарга Э.Тамир, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, мөн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил нэгжийн Зээлийн санхүүгийн шинжээч Л.Мягмартүвшин, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн зохицуулагч Д.Ганбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх Ш.Батцэнгэл нар байлцав.

Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаар Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг сонсов.

*Уг асуудлыг 15 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайланг хэлэлцэх***

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан ажлын хэсгийн бүрэлдэхүүн дутуу тул уг асуудлыг хойшлуулав./15:42/

***Дөрөв. “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл /Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн тогтоолын төслийн талаар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** “Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:

7

Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

“Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, Г.Тэмүүлэн нар ажиллахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 47 минут үргэлжилж, 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 45 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Их засаг” танхим,  
13 цаг 58 минут

### **ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг танилцуулъя.

Жигжидийн Батжаргал гишүүн,  
Хавдисламын Баделхан гишүүн,  
Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн,  
Сайнхүүгийн Ганбаатар гишүүн,  
Салдангийн Одонтуяа гишүүн,  
Бөхчулууны Пүрэвдорж гишүүн,  
Шатарбалын Раднаасэд гишүүн,  
Цэндийн Сандаг-Очир гишүүн,  
Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн,  
Баттогтохын Чойжилсүрэн гишүүн  
хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1 дүгээрт, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Ундрам нарын 7 гишүүн өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, санал,

дүгнэлтээ БОХХААБХ-нд хүргүүлэх асуудал байна.

2-т, Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаарх гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэх асуудал байгаа.

3-д, Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-25 оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх байгаад байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Одонтуяа гишүүн байна. Одонтуяа гишүүнээр тасалъя. Одонтуяа гишүүний микрофоныг өгье. Одонтуяа гишүүн.

**С.Одонтуяа:** Хэлэлцэх асуудлуудыг дэмжиж байна. Тэгээд төгсгөлд нь нэг ажлын хэсэг байгуулж өгөөч гэсэн санал байгаа. Угаасаа нөгөө хэлэлцэх хугацаа нь цөөхөн, тэгээд ганцхан заалттай хууль учраас эртхэн ажлын хэсгийг нь байгуулъя гээд.

**Г.Тэмүүлэн:** Одонтуяа гишүүн хэлэлцэх асуудлын жагсаалтад ажлын хэсэг байгуулах асуудлыг нэмэлтээр оруулъя гэсэн саналтай байна. Одонтуяа гишүүний саналаар санал хураалтыг явуулъя. Ажлын хэсэг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг дэмжье гэдэг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах асуудлыг дэмжье гэдэг томъёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

70 хувиар санал хураалт дэмжигдлээ.

Ингээд хэлэлцэх асуудлын жагсаалтад 4 дэх асуудал болгож, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэхийг дэмжиж, баталж орууллаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орцгооё. 1 дүгээр асуудал.

**Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ундрам гишүүн танилцуулна. Ундрам гишүүний микрофоныг өгье.

**Ч.Ундрам:** Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, энэ саяын татвартай холбоотой хуулиуд маань би болон нэр бүхий Улсын Их Хурлын 7 гишүүн хамтран өргөн барьсан Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төслийг дагалдаж орж ирээд Байнгын хороо болон Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх эсэх нь хэлэлцэгдээд, хэлэлцэхээр болоод ингээд явж байгаа ийм хууль байгаа юм.

Органик бүтээгдэхүүний тухай хууль нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах энэ Улсын Их Хурлын тогтоолтой яв цав уялдаж байгаа. Тэгээд мөн Алсын хараа 2050-д бид нар нийт хүнснийхээ 5 хувийг органик хүнс болгоно, 2030 он гэхэд гэсэн энэ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдаж байгаа ийм хууль байгаад байгаа юм. Тэгээд ер нь олон улсын чиг хандлагыг харахад Европын холбооны улс гэхэд л 2030 он гэхэд нийт хүнсний хэрэглээнийхээ 30 хувийг органик хүнс болгоно гэж байгаа юм. Яагаад органик хүнс гэж тусад нь бусад хүнснээсээ тусгаарлаж авч яваад байгаа

юм бэ гэхээр 1 дүгээрт хүмүүсийн эрүүл мэндтэй холбоотой асуудал байдаг. Монгол Улсын эрт элрүүлгийн үзлэгт хамрагдсан энэ өнгөрсөн 1 жилийн хугацаанд 1,3 сая хүний 71,1 буюу 668,5 мянга нь хоол боловсруулах тогтолцоо, бодисын солилцооны өвчлөлтэй бүртгэгдсэн. Тэгэхээр энэ бол ерөөсөө дийлэнх хувь нь хүнстэй шууд холбоотой байгаа. Манай улсад жишээлбэл хөрс эрүүл бол хүнс эрүүл, хүнс эрүүл бол хүн эрүүл гэдэг үг байдаг шүү дээ. Тэгэхээр бид нарын идэж байгаа энэ хоол хүнсэнд пестицид, гербицид гээд маш олон химийн хорттой бүтээгдэхүүнүүд ихээр агуулагдаад үүнийг нь эргээд бид нар идэж байгаа учраас бид нарын өвчлөл хорт хавдрын болон энэ хоол боловсруулах тогтолцоотой холбоотой өвчлөл маш их байгаа учраас бид нар энэ органик хүнсний одоо байгаа нэг хэдхэн үйлдвэрлэгч нараа бид нар дэмжих шаардлагатай учраас дагалдаж энэ татварын хуулиуд нь орж ирж байгаа юм.

Тэгээд энэ татварын хууль дээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг хөнгөлөе гэсэн ийм заалт орж ирж байгаа. Өнөөдөр манай нийт хүнсний үйлдвэрлэлийн 1 хувь ч хүрэхгүй нь органик гэсэн баталгаажуулалт авсан байгаа. Тэгэхээр бид нар өөрсдийгөө органик хүнс хэрэглэдэг ээ гэж яриад байдаг боловч энэ яг цаанаа органик гэж баталгаажаагүй органик биш байх магадлал өндөртэй ийм байгаа учраас бид нар үүнийгээ одоогийн хүнс үйлдвэрлэж байгаа хүмүүсээ дэмжье татварын бодлогоор, цаашид органик хүнс үйлдвэрлэх тэр хөшүүргийг бий болгож өгье. Улмаар энэ хүн амынхаа эрүүл мэндийг үүний үндсэн дээр хамгаалъя, нийгмийн эрүүл мэндэд тустай гэсэн ийм асуудал.

2 дугаарт, ач холбогдол нь байгаль орчны ач холбогдолтой байгаад байгаа юм. Энэ ҮСХ-ны дүнгээр Монгол Улсын хохирол учирч доройтсон талбайн

хэмжээ сүүлийн 5 жилийн хугацаанд 2,8 сая га-аар буюу 45,7 хувиар нэмэгдсэн байгаад байгаа юм. Тэгээд энэ нь ерөөсөө хүнс ногоо тарьж байгаа хүмүүс маш их хэмжээний химийн хортой бодис их хэмжээгээр зөвшөөрөгдсөн түвшнээс ихээр ашиглаад байгаатай холбоотой. Гадаад олон улсын судалгаануудыг харахаар органик тариалалтыг хэрвээ эрхлэх юм бол хөрс эргээд сайжирдаг. Хөрсний чанар нь эргээд сайжирдаг, хөрсний ялмаг, азот, фосфор, калийн хэмжээ нь бүр 100 гаруй хувиар ингээд өсдөг байгаад байгаа. Органик тариалалт эрхлэх юм бол. Тийм учраас бид нар хөрсөө, байгаль орчноо бодсон ч гэсэн хүн амынхаа эрүүл мэндийг бодсон ч гэсэн энэ татварын хөшүүргүүдийг оруулж өгөх нь зайлшгүй шаардлагатай байгаа.

Энэ хуулийг боловсруулахад бид нар Европын холбооны хамгийн эрүүл хүнстэй гэж яригддаг энэ улс орнууд ялангуяа Германы хуулийг судалсан байгаа. Эд нар ерөөсөө хамгийн гол хөшүүрэг нь энэ татварын бодлогоор органик хүнс үйлдвэрлэгч нараа дэмждэг. Яагаад вэ гэхээр органик хүнсийг тариалахад маш их гар ажиллагаа ордог маш хүндрэлтэй байдаг. Дээрээс нь нөгөө янз бүрийн химийн бордоо хэрэглээгүй учраас жишээлбэл жимс жимсгэнэ, төмс хүнсний ногоо нь их жижигхэн хэмжээтэй гардаг ч юм уу. Тариалалт арай бага авдаг, зэрлэгээ өөрсдөө гар аргаар түүдэг, хөрсөө хэдэн жилээр бэлддэг, баталгаажуулах процесс нь маш ярвигтай байдаг гээд өндөр зардлаар энэ органик хүнс, бүтээгдэхүүнийг бүтээдэг учраас ийм татварын хөшүүрэг тавихгүй бол бусад бүтээгдэхүүнтэй үнийн хувьд өрсөлдөх чадвар нь маш хэцүү байдаг юм. Тийм учраас бид нар ийм татварын хөшүүрэг тавьдаг гэж энэ Европын холбооны улс орнууд ярьж байгаа юм.

Тийм учраас бид нар яг эндээ оруулж өгч байж одоо байгаа нэг хэдхэн хүмүүсээ дэмжихээс гадна бусад малчид,

тариаланчдыг бид нар идэвхжүүлнэ гэж бодож байгаа.

Мөн дээрээс нь гадаад улс орнууд Монгол Улсыг органик хүнс бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг гэж гаднын улс орнууд хардаг. Гэтэл яг юмыг чинь авъя, нөгөө баталгаажуулсан бичиг баримт нь хаана байна вэ гээд асуухаар тэр нь байдаггүй. Яг баталгаатай манай энэ малын арьс, шир, ноос ноолуур, мах ч байдаг юм уу эдгээр бүтээгдэхүүн органик юм гээд манай малчид баталгаажуулалт гаргаж өгч чаддаггүй учраас өндөр үнээр экспортлох боломжгүй байдаг. Гэтэл уул нь нөгөө талдаа эрэлт байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хууль маань хэрэгжсэнээр малчид маань жишээлбэл малын мах, арьс шир, ноос ноолуураа органик юм гээд баталгаажуулах юм бол олон улсад яг органик гээд өндөр үнээр борлуулах энэ боломжууд нь нээгдэх юм. Тэгэхээр яалт ч үгүй энэ татварын хөшүүргүүд шаардлагатай байгаа учраас энэ Төсвийн байнгын хороогоор та бүхнээр хэлэлцүүлээд тэгээд санал, дүгнэлтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлэх шаардлагатай байгаа юм.

Тэгээд та бүхнийг дэмжиж өгөөч ээ гэж хүсэж байна.

**Г.Тэмүүлэн:** Ундрам гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя.

Есөн-Эрдэнэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга. Хөдөө аж ахуйн яамнаас хүн байна уу? Есөн-Эрдэнэ даргыг дуудаарай. Гийхнаран Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга, Тунгалаг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Органик хүнс, хүнсний сав баглаа



боодлын асуудал хариуцсан ахлах шинжээч, Мөнхшүр Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн, Алтанцэцэг НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Тонгол ногоо төслийн эрх зүйн орчин төслийн менежер, Энхтуяа “Органик хөгжил” ТББ-ын гишүүн, Алтанхуяг “Хүнс, хөдөө аж ахуйн хөгжлийн үндэсний нэгдэл” ТББ-ын тэргүүн, судлаач, Отгонсайхан МУИС-ийн Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш, профессор, Энхжаргал Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн зөвлөх гэсэн байна.

Ингээд хуулийн төсөлтэй холбогдуулаад гишүүд асуулт асууж болно. Хуулийн төсөлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсийг авъя. Батжаргал гишүүн үү. Баттөмөр гишүүнээр тасалъя. Баделхан гишүүн асуулт асууя.

**Х.Баделхан:** Баярлалаа. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ бол маш чухал дотоодын үйлдвэрлэлээ дэмжсэн. Тэгээд органик хүнсээ дэмжсэн ийм чухал хуулийн төсөл л дөө. Хуулийн төслийг дэмжиж байгаа. Гэхдээ яг органик гэдгийг нь чухам яаж баталгаажуулах юм бэ? Яг өнөөдрийн байдлаар бидэнд цэвэр органик хүнс үйлдвэрлэж байгаа тийм үйлдвэр байгаа юу. Яг өнөөдрийн байдлаар. Ер нь органик гэдгийг нь ямар нөхцөлд хэн баталгаажуулах юм бэ гэсэн энэ хамгийн гол нь энэ хууль хэрэгжихэд л их хэцүү л дээ.

2 дахь нь, зүгээр энэ иргэдийн дунд нөгөө гаднаас хямдхан хүнс оруулж ирээд тэгээд ингээд дотооддоо ингээд баглааг нь хийгээд энэ чинь “Монголд үйлдвэрлэв” гэсэн юугаар зардаг гэсэн мэдээлэл байдаг юм. Энэ амьдрал дээр байдаг болов уу гэсэн ийм 2 асуулт байна. Энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Баделхан гишүүнд баярлалаа. Баделхан гишүүний асуултад хариулъя. Ундрам гишүүн хууль санаачлагч хариулах уу? Тэгье. Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Баделхан гишүүн маш чухал асуулт асууж байна. Манай улсад өнөөдөр яг энэ баталгаажуулалтыг хийдэг 25 хамтын баталгаажуулалтын, 2 хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллага яг энэ органик хүнсний баталгаажуулалтыг хийгээд тэгээд [organic.gov.mn](http://organic.gov.mn) гээд ийм веб сайт нээчихсэн. Эндээ энэ мэдээллийн санд органик бүтээгдэхүүнүүдийг бүртгүүлээд явж байгаа. Тэгээд баталгаажуулсан бүтээгдэхүүнүүддээ Монгол Улсын органик гэсэн ийм шошгыг хэрэглүүлээд тийм ээ, шошго хаяг дээр нь хэрэглүүлээд ингээд байж байгаа. Тэгээд энэ веб сайтад өнөөдрийн байдлаар баталгаажсан 257 органик, органик руу шилжиж байгаа шилжилтийн үеийн 30, импортоор орж ирдэг баталгаажуулчихсан 80 органик хүнс бүртгэлтэй байгаад байгаа юм. Тэгээд ерөнхийдөө энэ тийм өндөр тоо биш ч гэсэн өнгөрсөн хугацаанд манай Хөдөө аж ахуйн яам дээр хийгдсэн нэлээн том дэвшилттэй ажил байгаа юм. Тэгээд үүнийг бид нар өшөө цаашлаад нэмэгдүүлэх, эндээ аль болохоор олон малчид, тариаланчдаа хамрагдуулах, мөн улсын бодлогоор дэмжих ийм зорилгоор энэ хуулийн төслийг өргөн барьж байгаа. Тэгээд энэ бүртгэлтэй жишээлбэл үлэмж органик гээд хүнсний сүүн бүтээгдэхүүнүүд байдаг. Энэ нь ингээд дэлгүүрүүдээр байж байгаа. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Нэмэлтээр ажлын хэсгээс хариулъя. Гараа өргөөрэй. 1 номер албан тушаал нэрээ танилцуулаарай.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ахлах шинжээч Тунгалаг байна. Ер нь органик бүтээгдэхүүний хувьд хамгийн хэцүү асуудал нь хуурамч бүтээгдэхүүний

асуудал байдаг. Үнэхээр баталгаажсаагүй, тэгээд бүртгэлгүй тийм хүнсийг органик гэж шошголоод зарагдах тийм асуудал зөндөө байгаа. Энэ дээр мэдээж манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газрынхан маш сайн ажиллах ёстой. Тэгээд мэдээж баталгаажуулалтын байгууллага өөрсдийнхөө зүгээс тодорхой хэмжээний хяналтыг тавьж ажиллах ёстой. Тэгээд ер нь энэ хууль батлагдсанаар, энэ шинэчилсэн найруулга батлагдсанаар энэ органик бүтээгдэхүүнийг баталгаажуулах, шошголох, тэгээд бүртгэх энэ асуудлууд эргээд илүү тийм зохион байгуулалттай, илүү сайжирч орж ирж байгаа. Энэ хуулийн төсөл дээр.

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Энэ цаг үеэ олсон маш чухал хууль орж ирж байна. Дэмжиж байгаа. Ер нь “Монгол” гэдэг нэр чинь өөрөө “органик” гэсэн нэр юм байгаа юм шүү дээ. Энэ том давуу талаа бид ашиглаагүй их олон жил болсон. Анх энэ хууль Органик хүнсний тухай хууль 2016 онд гарсан. Тэгээд энэнээс хойш олигтой үр дүн гараагүй. Манай улс 2030 он гэхэд нийт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийхээ тавхан хувийг органик баталгаажуулахад хамааруулна л гэж зорилт тавьж байгаа. Ер нь тааруу байгаа. Энэ хууль яагаад хэрэгжээгүй гэвэл 1 дүгээрт, органик үйлдвэрлэлийн төрөөс дэмжих нэгдсэн бодлого ерөөсөө өнөөдөр хүртэл олигтой яваагүй, ерөөсөө нэгдсэн бодлого байхгүй.

2 дугаарт, миний зүгээр их санаа зовдог л юм л даа. Органик үйлдвэрлэл эрхлэх, органик бүтээгдэхүүн үйлдвэрлэл өнгөрсөн 5 жилд ингээд удааширалтай байгаа нь төрөөс тэр стандарт болон төрийн дэмжлэг байхгүй гэдгийг л би онцолж хэлж байгаа юм шүү. Энэ дээр одоо орж ирж байгаа санал бол Органик

хүнсний тухай хууль биш Бүтээгдэхүүний тухай хууль гэдгээрээ бид бүтээе, бий болгоё, малчид, тариаланчдаараа бид нэг орлого нэмүү өртөг шингээе гэдэг давуу тал. Энэ бидний ирээдүй. Тэгэхээр энэ дээр зүгээр тунхгийн төдий хайртай шүү гэж хэлчхээд л давхиад байдаг төртэй улс шүү дээ бид чинь. Тэгээд ямар их муухай тунхгийн балиар, тэр чинь бараг гай болж байгаа юм шүү дээ. Зүгээр дуугүй байсан нь бараг шулуун юм байгаа юм даа, уг нь.

Тэгэхээр энэ хууль дээр миний асуулт ийм байна. Хуулийн төсөлд Засгийн газрын санал ирсэн үү? Шаргаагаад, чангаагаад, татаад таталдчихсан байх вий. Энэ дээр яамныхан хариулах байх. Ирсэн үү? Ирсэн бол органик бүтээгдэхүүнтэй холбоотой зардал хариуцах гээд энэ хуулийг харахад 15.1.1, 15.1.2, 15.1.3, 15.2.2, 15.2.3, 15.2.5 гэсэн 6 хэсэг дээр ямар ч эзэн бие алга. Энэ хууль дээр. Би дэмжиж байгаа учраас ярьж байгаа юм шүү. Дараа нь үүнийг хэрэгжүүлэхгүй болоход төр ямар ч буруугүй гэмээргүй байна. Энэ дээр төрөөс зохицуулалт хийх ёстой, дэмжих ёстой. Тэр эзэн бие нь тодорхой баймаар байна. Энэ зардлуудыг эзэнжүүлмээр байна.

Үүний 15.3-д заасан журмаар зохицуулах нь л гэж та нар хариулах байх. Энэ тийм боломжтой юм уу. 15.3-ын журам ч, би одоо үг, үсгээр нь бүгдийг нь уншмааргүй байна шүү. Надад хугацаа нь ч бага байна. Тэгэхээр зардал, хөнгөлөлт, чөлөөлөлт би хамгийн дургүй асуудал. Орж ирэх болгондоо л лоббичид орж ирээд л татвараас хөнгөлье, зардлаас хөнгөлье, Засгийн газрын нэмэлт мөнгө өгье гээд л дандаа тэгдэг. Энэ органик бүтээгдэхүүн дээр бол дүүрсэн хэрэг. Энэ бол байх ёстой зүйл. Энэ дээр дэмжиж байна. Тэгэхээр дэмжсэн юм бол тодорхой бай. Хариуцагч тодорхой болгомоор байна. Би түрүүний 7 заалт ярилаа. Журам яг журмаар зохицуулна гэвэл тэр журам энэ дийлэх үү. Ийм хууль бодитой биелэх

үндэслэлийн талаар би асуулт асуулаа. Надад хариулт өгнө үү? Хэрвээ хүсвэл би дахиад асуултаа давтаж болно шүү.

**Г.Тэмүүлэн:** Хэн хариулах вэ? Ганбаатар гишүүний асуултад Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Ганбаатар гишүүнд баярлалаа. Яг нөгөө төрийн дэмжлэг байхгүй байж байж, лоозон хэлбэртэй байсан гээд яг нөгөө өмнөх хуулийн маань үнэн байдлыг хэллээ. Өмнөх хууль маань тэгэхдээ анх удаа бид нар нэг ийм Органик хүнсний тухай хууль гээд нэг ийм лоозон ч гэсэн нэг ийм хуультай болсон юм байна лээ. Одоо бид нар энэ сайжруулалт нь бүтээгдэхүүн болгож өргөжүүлээд, төрөөс 2 янзын мөнгөн хэлбэрийн болон мөнгөн хэлбэрийн бус ийм 2 төрлийн дэмжлэгүүдийг үзүүлье ээ гээд тэгж байгаа юм. Тэгээд энэ мөнгөн хэлбэрийн 3 дэмжлэгийг болохоор Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас улсын төсөвт энэ хууль 2025 оноос эхэлж хэрэгжинэ гэсэн ийм заалттай явж байгаа. Тэгэхээр 25 оноос эхэлж улсын төсөвт Хүнс, хөдөө аж ахуйн яам заавал тусгуулж батлуулаад тэгээд өөрсдийнхөө боловсруулсан журмын дагуу олгоно гэсэн ийм санаа явж байгаа.

Мөнгөн бус дэмжлэгүүд бол мэдээж юунууд дээр энэ яаман дээрээ ингээд хариуцагдаад явж байгаа юм. Тэгээд яг өнөөдөр энэ Төсвийн байнгын хороогоор хэлэлцэж байгаа энэ татварын дэмжлэг бол хамгийн том хөшүүрэг болох юм гэж бид нар харж байгаа.

Дээрээс нь энэ хуулийг дагалдаж гарч байгаа төрийн худалдан авалтад органик хүнсэнд ялангуяа сургууль, цэцэрлэгт давуу эрх олгоно гэсэн ийм дагалдах хууль гарч байгаа. Мөн дээрээс нь нөгөө уул уурхайн тухай хууль дээр уул уурхайн компаниуд нөхөн сэргээлт хийхдээ органик бордоо хэрэглэнэ ээ гэсэн бас заавал үүрэгжүүлээд өгчхөж байгаа юм. Тэгэхээр ингээд ийм

хөшүүргүүд оруулахгүй болохоор өмнө нь нөгөө уриа лоозонгийн хэлбэртэй гэхдээ яаман дээр байгаа нэг ганц хоёрхон мэргэжилтэн маань зүтгүүлсээр байгаад олон улсын их сайн Адра төслөөс авхуулаад олон сайн төслүүд хэрэгжсэний үндсэн дээр нэг ийм ямар ч л байсан нэг органик коммунити буюу органик хүнс үйлдвэрлэгчидтэй болчхоод байгаа юм. Одоо эд нартайгаа би ингээд уулзаад яах вэ, яаж дэмжих вэ гээд асуухаар яг таны хэлсэнчлэн энэ татварын бодлогоор дэмжих хэрэгтэй байна. Яг бодит дэмжлэг бид нарт хэрэгтэй байна гэсэн учраас энэ 15.1-ээс 3-ын мөнгөн хэлбэрийн болон өнөөдөр энэ Төсвийн байнгын хороо хэлэлцүүлж байгаа Татварын тухай хуулиудын дэмжлэгүүдийг тусгаж оруулж ирсэн юм.

Тэгээд Тунгалаг дарга нэмээд хариулчих.

**Г.Тэмүүлэн:** Тунгалаг дарга. Засгийн газраас ирүүлсэн санал хэрхэн. 1 номер.

**Д.Тунгалаг:** Ер нь Ганбаатар гишүүний өгсөн чиглэлийн дагуу томъёолол дээрээ ерөнхий дахиад ажиллая. Энэ дээр нөгөө эзэн бие байхгүй байна гээд тэгсэн. Уул нь яах вэ, төрөөс органик үйлдвэрлэл эрхлэгчид үзүүлэх дэмжлэг гээд илүү ингээд нөгөө ерөнхий байдлаар оруулчихсан байгаа л даа. Үүнийгээ тийм, бүтцийн хувьд ерөнхийдөө Хүнс, хөдөө аж ахуйн яам, орон нутгийн хүнс, хөдөө аж ахуй хариуцсан төрийн байгууллагууд хамаараад явж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Уг нь их тодорхой асуултауд асуусан. Засгийн газраас ямар санал өгсөн бэ? Энэ төрийн дэмжлэгтэй холбоотой. Ганбаатар гишүүн нэмээд тодруулчихъя даа. Тэгээд та дахиад тодруулж.

**С.Ганбаатар:** Хайртай шүү гэдэг чинь уг нь цаанаа хариуцлага юм байгаа

юм шүү дээ. Дурлалцаад л яваад байхын нэр биш шүү дээ уг нь, би хариуцлага үүрье ээ л гэж байгаа юм шүү дээ. Төрөөс би хайртай гэж байгаа бол. Энэ чинь бидэнд их мөнгө оруулж ирэх юманд төр татганаж болохгүй, дэмжлэгээ үзүүлэх ёстой байхгүй юу.

15.1. Органик үйлдвэрлэл эрхлэгчийн дараах үйл ажиллагааг доор дурдсан мөнгөн дэмжлэг үзүүлнэ гэж байгаа юм. Тодорхойгүй.

15.1.1. Шилжилтийн үеийн баталгаажуулалтын зардал. Хэн хариуцах юм, хэд юм, бүү мэд.

15.1.2. Олон улсын хэмжээнд зохион байгуулах үзэсгэлэн худалдаанд органик бүтээгдэхүүн оролцуулах зардал. Хэн ч тодорхойгүй.

15.1.3. Органик бордоо, бордох худалдан авах эхний 3 жилийн зардлыг нь төр хариуцна. Тодорхойгүй.

15.2. Ингээд би цаашаа бүгдийг нь унивал 15.2.2 бүр ноцтой асуудал байгаа шүү. Заасан зээлийн 50-аас доош хувьд хуулийн дэмжлэг, хуулийн дэмжлэг үзүүлэх, хуулийн дэмжлэг гэдгийг би нэг сайн ойлгохгүй.

**Г.Тэмүүлэн:** 1 номер.

**Д.Тунгалаг:** Ерөнхийдөө бол. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн органик бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортод төрөөс үзүүлэх дэмжлэг урамшуулалтай холбогдох журмыг батална гээд уул нь байгаа. Тэгээд энэ асуудлыг жоохон тодорхой болгоод дахиад томъёолоод ороод ирье. Уул нь үүнийг журмаар зохицуулахаар бид нар зохицуулалтыг нь оруулсан байгаа л даа. Хуулийн төслийн 15.3 дээр байгаа. Тэгээд Засгийн газрын хуралдаанаас тэмдэглэлээр бид нарт үүрэг өгсөн. Тэр дагуу бид нар энэ төрийн

байгууллагуудын чиг үүргийг нэмж оруулсан байгаа.

**Г.Тэмүүлэн:** Одонтуяа гишүүн асуултаа асууя.

**С.Одонтуяа:** Тэгэхээр энэ ач холбогдол бол агуу байгаа. Үүнтэй хэн ч маргахгүй. Гэхдээ бид нар чинь сүүлийн үед энэ хаширчхаад байна. Ерөөсөө энэ хэнд ч итгэхгүй болчихоод байна. Нүүрсний хулгай гэдэг шиг сүүлдээ энэ органик бүтээгдэхүүн хийдэг шошгоны хулгай гэдэг ч юм уу, улсын комисс нөгөө байр байшин хүлээж авдаг шүү дээ. Ямар юм хүлээж авдгийг нь бүгдээрээ мэдэж байгаа. Тэгээд өнөө нэг комиссын хулгай ч гэдэг юм уу ийм юм л гарах вий дээ. Эндээс сэргийлсэн юм юу байгаа? Аливаа нэг хүнд зөвшөөрөл өгдөг юм гэдэг чинь заавал ардаа авлигыг дагуулдаг. Тэгэхээр үүнийгээ яаж шийдсэн юм бэ? Түүнээс биш агуулгыг нь дэмжиж байна. Одоо нэг хятад бизнесмен ирээд тэгсэн гэсэн. Хөөх танайх чинь бараг энэ бүтээгдэхүүнүүдээ зүгээр хил давуулаад шидээд байхад л ёстой маш өндөр, чухал бүтээгдэхүүн байна шүү дээ гэж. Тэгэхээр үнэхээр Монгол энэ органик бүтээгдэхүүнээ дэмжье гэдэг дээр маргахгүй байгаа. Тэгэхээр яг энэ процедурын юмыг яаж зохион байгуулсан юм бэ?

2-т, энэ компаниуд эндээс шошго авахын тулд ямар нэгэн хураамж төлөх үү? Тэгээд энэ сурталчилгаагаар сайн хийх хэрэгтэй. Хэрвээ эд нараас ингээд хураамж авч байгаа бол энэ хураамжийг нь юунд зарцуулах юм бэ гэдэг юм асууя. Яагаад гэхээр сурталчилгаа байхгүй бол энэ өөрөө нэг их явахгүй ээ.

Ер нь тэгээд энэ дэлгүүрийн лангуун дээр яг төрийн бодлого явдаг юм байна лээ. Жишээлэхэд, Америкт дайны дараа лангууны тэргүүн эгнээнд дандаа хүмүүсийг таргалуулдаг ийм сахрын агууламж ихтэй, хурдан жин нэмдэг ийм бүтээгдэхүүнүүдийг тэргүүн эгнээнд ингээд тавь аа. Тэгж байж хүмүүс энэ

дайны дараах өлсгөлөн энэ жингийн алдалтыг нөхнө өө гэдэг ийм төрийн бодлого явдаг юм байна лээ. Тэгэхээр манайх энэ органик бүтээгдэхүүн дээр энэ аж ахуйн нэгжүүдтэй ярилцах, тэр лангууны байршуулалт дээр тохирч байгаа юм байгаа юу гэсэн ийм зүйл асуух гэсэн юм. Ер нь энэ чинь яах вэ бусад оронд ингээд л органик гээд дэмжээд л байгаа шүү дээ. Тэгэхээр энэ манайх яг энэ органик бүтээгдэхүүнээ дэлгүүрт борлуулахад ямар нэгэн зохицуулалт байгаа юу?

**Г.Тэмүүлэн:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. 1 номер.

**Д.Тунгалаг:** Одонтуяа гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт, хураамжийн асуудал ярьсан. Өнөөдрийн байдлаар органик хүнсийг баталгаажуулах зардлыг аж ахуйн нэгжүүд өөрсдөө тохирч байгаа, аж ахуйн нэгж болон төрийн байгууллага. Тэгэхээр тэр асуудалд төр хөндлөнгөөс оролцох боломжгүй байгаа. Баталгаажуулалтын зардлыг 2 аж ахуйн нэгж, нэг баталгаажуулалтын байгууллага Стандартчилал хэмжил зүйн газрын дэргэд төрийн баталгаажуулалтын байгууллага байдаг. Эдгээр байгууллагууд баталгаажуулалтын зардлыг өөрсдийн тогтоосон жишиг хэмжээний дагуу зардлаа тогтоогоод явж байгаа.

Бүртгэхэд ямар нэгэн тэмдэгтийн хураамж байхгүй. Бүртгэх асуудал ямар нэгэн төлбөргүйгээр явж байгаа. Сурталчилгааны асуудал үнэхээр чухал. Органик бүтээгдэхүүн дээр. Тэгэхээр органик бүтээгдэхүүний сурталчилгааг улсын хэмжээнд хэрэгжүүлэх тэр үйл ажиллагааг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зангидаад явахаар энэ хуулийн төсөл дээр тусгагдсан байгаа.

**Г.Тэмүүлэн:** Нэмж Ундрам гишүүн хариулъя.

**Ч.Ундрам:** Энэ нөгөө сурталчилгааны асуудал маш чухал юм гээд Одонтуяа гишүүнтэй санал нэг байна. Манай хэрэглэгчид өөрсдөө яг органик хүнс гэж юу юм, яаж ялгах юм, надад ер нь ямар хэрэгтэй юм гэдгийг огт мэддэггүй юм байна лээ. Тэгээд тийм учраас бид нар энэ хуулийн төслийн 15.2.5 дээр органик бүтээгдэхүүнтэй холбогдох мэдээлэл, сургалт сурталчилгааг улсын төсвөөс санхүүжүүлнэ гээд энэ яаманд үүрэг болгоод энд оруулчихсан байгаад байгаа. Тэгээд яг органик Монгол Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас боловсруулчихсан шошго хүртэл ингээд гарчихсан байгаад байдаг. Гэтэл тэр шошгыг ингээд ард иргэдэд үзүүлээд энэ юутай холбоотой шошго, та мэдэх үү гэхээр мэдэхгүй юм байна лээ. Тэгээд энэ шошгыг хүмүүс мэдэхгүй байгаа учраас өөр үйлдвэрлэгчид хуурамчаар шал өөр зүгээр эко ч гэдэг юм уу ийм юм бичээд, наагаад, зарахаар тэрийг нь органик гэж бодох тийм андуурал, хуурах асуудал ч гэсэн гарахаар байгаад байгаа юм.

Тэгээд энэ хуулийн төсөл дээр бид нар 17 дугаар зүйл дээр нь хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага гээд ийм дэд бүлэг оруулаад өгсөн байгаа. Тэгээд холбогдох хариуцлагуудыг энэ хуулийнхаа дагуу болон холбогдох Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулиудаар хариуцлага хүлээлгэнэ гээд оруулсан байгаа.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Бид нар чинь мэргэжлийн хяналтын байгууллагаа үндсэндээ цомхотголд оруулсан. Хяналт шалгалт нэлээн суларсан. Энэтэй холбоотойгоор бид нарын хүнсний аюулгүй байдал нэлээн суларсан гэж ингэж үзэж байгаа. Энэ үед энэ хууль орж ирж байгаа юм байна. Энэ бид нарын таваг дээр байгаа хүүхдүүдийн идэж байгаа чихэр, боов, жимс жимсгэнэ, чанарын баталгаажилт

хийгдсэн эсэхээ л сайн мэдэхгүй л байна л даа. Яг үнэнийг хэлэхэд. Хил гаалиар орж ирж байгааг нь ч мэдэхгүй байна, эх орныхоо хөрсөнд тарьсныг ч мэдэхгүй байна. Энэ тэгээд хуулиа органик хүнсний гэж байгаад яагаад бүтээгдэхүүн болгосноо нэг хэлээдхээч. Би хамрах хүрээгээ нэлээн өргөжүүлсэн юм болов уу гэж ингэж ойлголоо. Бүтээгдэхүүн гэхээр. Тэгэхээр малын гаралтай бүтээгдэхүүнүүд орж ирэх юм шиг байна, тийм үү. Манай энэ улсын чинь гол нэрийн бүтээгдэхүүн болсон ноолуур, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлүүд энд орох уу? Эсгий, эсгий гутал, гэрийн дээвэр, туурга хийж байгаа энэ чиглэлээр малын гаралтай бүтээгдэхүүнээр бүтээгдэхүүн хийж байгаа аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлээ бараа бүтээгдэхүүнээ баталгаажуулалтад хамруулаад ингээд зах зээл дээр борлуулахад энэ хуулийн үйлчлэлд хамрагдахаар байна уу гэдгийг тодруулж өгөөч.

Нөгөө талаар энэ чинь татвартай холбоотой хууль учраас энэ чинь төсөв баталчихсан үед энэ чинь яах билээ? Хэрэгжих нь. Хориотой биш билүү, үгүй билүү. Өдийд чинь төсвийн жил, үндсэндээ бараг дуусаад шинэ төсвийн жил эхлэх гэж байгаа үед татвартай холбоотой хууль орж ирдэг чинь хориотой байдаг байх шүү. Энэ дээр нэг тайлбар хэлээч. Нөгөө талаар тариалсан болон үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс олсон орлогод гэх үү. Харин борлуулсны орлогоос уу, хөнгөлөх үү? Үүнийг нэг тодорхой хэлж өгөөч? Борлуулсны орлогоос уу, үйлдвэрлэсэн тариалсан бүтээгдэхүүний орлогоос уу? Энэ 2 ялгаатай шүү. Үүнийг нэг тодруулж өгөөч.

**Г.Тэмүүлэн:** Ундрам гишүүн асуултад хариулъя.

**Ч.Ундрам:** Манай хуулийн хүрээ таны хэлсэнчлэн өргөсөж байгаа. Тэгээд энд органик хүнснээс гадна бордоо, арьс шир, гоо сайхны бүтээгдэхүүн гээд өргөн

хүрээнд органик бүтээгдэхүүн гэдгээр нь авч үзэж байгаа. Тэгэхээр арьс шир, ноос ноолууран бүтээгдэхүүнүүд, гоо сайхны бүтээгдэхүүнүүд хэрвээ баталгаажуулалтаа хийлгэчих юм бол органик гэдэг байдлаараа дотоодын болон гадаадын зах зээл дээр ингэж борлуулагдана гэсэн үг. Органик гэдэг тодотголын доор.

Энэ хууль маань 2025 оноос хэрэгжинэ гэж орж ирж байгаа юм. Тийм учраас бид нар нөгөө 25 оны төсвөөс өмнө буюу ингээд батлагдчих юм бол 25 оны төсөвтэй холбогдох зардлуудыг суулгаад явна.

Юуны татварын хөнгөлөлтүүд мэдээж борлуулалтын орлогоос татварт тооцогддог учраас тэндээсээ хөнгөлөгдөөд явна гэж ойлгож болно.

**Г.Тэмүүлэн:** Нэмж тодруулъя Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Тэгэхээр энэ хуулийн концепцыг дэмжиж байна. Үнэхээр чухал хууль байна. Тэгээд үүнтэй дагалдуулаад энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн энэ 10.1-ийг тодруулаач? Энэ дээр ямар заалтад өөрчлөлт орж байгаа юм. Нэгд, дагасан хууль дээр.

2-т, энэ хууль хэрэгжиж эхэлснээр яг аж ахуйн нэгжид ямар ач тустай вэ, үр дүнгээ өгөх вэ. Иргэдэд ямар үр дүн гарах вэ гэдгийг нэг тодруулж өгөөч.

Нөгөө талаар төсөвт ямар дарамт гэдэг юм уу, ачаалал ирэх вэ? Түүний орон зайг юу гэж харж байгаа вэ? Үүнийг нэг тодруулж өгөөч, эдийн засгийн тооцоо судалгааг нь.

**Г.Тэмүүлэн:** Ундрам гишүүн асуултад хариулъя.

**Ч.Ундрэм:** Төрийн худалдан авалттай холбоотойгоор органик бүтээгдэхүүнд давуу эрх олгоно гэж байгаа юм. Тэгээд энэ нь яг явж явж, хаана очих вэ гэхээр сургууль, цэцэрлэгийн үдийн хоол хөтөлбөрт хэрвээ тухайн сумын сургууль юм уу, цэцэрлэг хүнсний худалдан авалтаа хийх юм бол, органик хүнсний үйлдвэрлэгч байх юм бол тэрэнд нь давуу эрх олгоно гэсэн ийм агуулгаар орж байгаа гэсэн үг.

Тэгээд юуны үр дүнгийн хувьд бид нар аж ахуйн нэгжийн хувьд ингээд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас жишээлбэл 90 хувь хөнгөлөгдөх юм бол нэлээн том дэмжлэг болж байгаа юм. Тэгээд органик хүнс үйлдвэрлэснийхээ дагуу төрийн худалдан авалтад давуу эрх авчих юм бол илүү борлуулалт дээр нь дэмжлэг болно гэж үзэж байгаа.

Тэгээд зар сурталчилгаа болон түрүүн энэ 15 дугаар зүйлийн дэмжлэгүүд энэ хууль батлагдсанаар энэ аж ахуйн нэгж ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Ундрэм гишүүн гүйцээж хариулъя. Сая сүүлийн асуудлууд байгаа. Төсөв дээрх ачаалал гээд.

**Ч.Ундрэм:** Мөн тэгээд эрүүл мэнд, байгаль орчин гээд олон талын ач холбогдолтой гэж үзэж байгаа. Төсөв дээр дарамт байхгүй. Яагаад гэвэл өнөөдөр манай нийт хүнс үйлдвэрлэлийн 1 хувь ч органик хүнс хүрдэггүй. Тэгэхээр тэндээс 1 тэрбум маш бага мөнгө байгаа. Тэр нарийн тооцооллыг манай Тунгалаг дарга хэлэх байх. Тэр ордоггүй мөнгийг л бид нар хөнгөлөх гээд байна л гэсэн үг болж байгаа юм. Тэгэхээр ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** 1 номер.

**Д.Тунгалаг:** Органик хүнсний бүртгэл мэдээллийн сан дээр өнөөдрийн байдлаар нэг 3 зуугаад бүтээгдэхүүн, тэгээд дээрээс нь шинэ цөлжилтийн үеийн нэг 70 орчим бүтээгдэхүүн,

импортын нэг 70 орчим бүтээгдэхүүн байгаа. Тэгээд эдгээр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа хүмүүсийг ингээд ангилаад үзэх юм бол 27-28 нь ерөнхийдөө аж ахуйн нэгж байгаа. Тэгээд бусад үйлдвэрлэгч 200 гаруй үйлдвэрлэгч нь дандаа хувиараа хөдөлмөр эрхэлдэг, хүнсний ногоочин, малчид байгаа. Тэгэхээр эдгээр хүмүүсийн орлогод бид нар тодорхой хэмжээгээр татварын дэмжлэг үзүүлэх юм бол энэ маань миний тооцоолсноор ер нь тэрбум 600 саяас жилдээ давахгүй юм байна л гэж үзэж байгаа юм. Тийм, хөнгөлөлт нь.

**Г.Тэмүүлэн:** Сандаг-Очир гишүүн яг тодорхой асуулт асуулаа. Зүгээр энэ дээр Сангийн яам яг ямар байр суурьтай байгаа юм бол. Хэн байгаа билээ? Сангийн яамнаас гараа өргөөрэй. 3 номер Гийхнаран. Сангийн яам 3 номер.

Сангийн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Гийхнаран. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн одоо яг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль дээр 10.1.1-д энэ Монгол Улсад Монгол Улсын гарал үүсэлтэй бараа бүтээгдэхүүнд давуу эрх олгоно гэсэн заалт байгаа. Тэгээд энэ заалтаар ер нь органик хүнсний бүтээгдэхүүн энэ Монгол Улсад үйлдвэрлэсэн гэдэг энэ юундаа ороод явчихна гэж бодож байгаа.

Дээрээс нь энэ хуулийн 19.1.2 дээр энэ дотоодын давуу эрх олгох энэ бүтээгдэхүүний жагсаалтыг Засгийн газар батлахаар заасан байгаа. Үүний дагуу Хүнс, хөдөө аж ахуйн яам тэр жагсаалтыг, барааны жагсаалтыг оруулж ирдэг. Түүн дээр Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан ийм органик бүтээгдэхүүн ингээд жагсаалтдаа батлаад оруулчихвал угаасаа энэ хүчин төгөлдөр байгаа давуу эрх олгож байгаа заалтад орчихно.

Дээрээс нь Ундрaм гишүүний түүрүүний хэлсэн боловсролын салбарт жишээлбэл хүүхдийн үдийн хоолыг органик хүнсээр ингээд хангана гэсэн шийдвэр гарлаа гэж бодоход тухайн салбар нь өөрөө ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Тэгэхээр Гийхнаран дарга тендерийн хуульд оруулж байгаа зохицуулалт угаасаа тусчихсан байгаа, хамрагдах хүрээнд байгаа гэж ярьж байна, тийм ээ, шинэчилснээрээ.

Сая та зүгээр тендертэй холбоотой хэн Сандаг-Очир гишүүн асуугаад байгаа юм бол, энэ чинь бас юу асуугаад байгаа шүү дээ. Татварын хуулийн өөрчлөлт хувь хэмжээний асуудал. Тэгэхээр энэ аж ахуйн нэгж болоод хувь хүний орлогын албан татвар, Нэмүү өртгийн албан татвартай холбоотой асуудлуудыг ярьж байна. Энэ дээр та хэд нэмээд тодруулах биз. Сангийн яамнаас 3 номер Мөнхишүр. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга.

Сайн байна уу? Сангийн яамны Татварын бодлогын газрын мэргэжилтэн Мөнхишүр байна. Асуултад харцулъя. Яг Ундрaм гишүүнээс ирсэн саналд, бичиг дээр бид нар нөгөө саналаа татварын яг 3 хууль орж ирсэн байгаа. 3 хууль дээр бид нар нөгөө саналаа бичээд явуулсан.

1 дүгээрт нь, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг 90 хувиар хөнгөлүүлье гэж орж ирсэн. Органик бүтээгдэхүүн байх юм бол бид хэд бол яг одоо байгаа мөрдөгдөж байгаа хуулийнхаа 22.5.1-д заасны дагуу 22.5.10-д заасны дагуу дотоодод үйлдвэрлэсэн, тариалсан жимс, хүнсний ногоонууд ингээд 50 хувиар хөнгөлөгдөөд явж байгаа.

Дээрээс нь хуулийн 22.1 дээр заасны дагуу 1,5 тэрбум хүртэлх орлоготой аж ахуйн нэгж байх юм бол

уул уурхай болон нөгөө онцгой албан татварт өгдөг төлдөг бараанаас бусад салбарын аж ахуйн нэгжүүд байх юм бол татварыг нь нөгөө аж ахуйн нэгжийн орлогын татвар 90 хувиар хөнгөлөөд явдаг угаасаа ингээд нөгөө хөнгөлөлтийн заалтууд маань тодорхой тусчихсан байгаа. Хувь хүн дээр мөн адил бас яг бид нар дотоодод бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, тариалсан, жимс, үр тариа, төмс хүнсний ногоо ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** 3 номер нэмээд хэлье.

**Ч.Мөнхишүр:** Орлогын албан татвараас 50 хувь хөнгөлөөд явж байгаа. Дээрээс нь дахиад нийслэл Улаанбаатар хотоос 500 км-ээс алслагдсан аймаг, сумд оршин суудаг, дээрээс нь ААН, хувь хүн нөгөө үйлдвэр үйлчилгээ явуулах юм бол түүн дээр нь яг 500 км-ийн зайн дээр, радиус дээр бид нар 50 хувийн хөнгөлөлт салбар хамаарахгүй хөнгөлж байгаа. 1000 км-ээс хол алслагдсан аймаг, сум дээр 90 хувийн хөнгөлөлт аж ахуйн нэгж, хувь хүн хоёулан дээр нь тусчихсан юм. Ерөнхийдөө бол ингээд нөгөө нэг хуулиуд дээр байгаа татварын хөнгөлөлтүүд маань энэ нөгөө орж ирж байгаа энэ нөгөө хэлэлцэж байгаа хууль дээр туссан хөнгөлөлтүүд тусчихсан байгаад байгаа.

НӨАТ дээр яг чөлөөлүүлье гэдэг заалт оруулж ирсэн байгаа. Хэрвээ НӨАТ дээр аягүй эрсдэлтэй байгаад байгаа юм. Бид нар яах вэ, НӨАТ дээр 13.1.15, 16, 17, 21 дээр заасных нь дагуу жимс жимсгэнэ дотоодод тарьж борлуулсан хүнсний ногоо, гурилыг угаасаа чөлөөлөөд явж байгаа.

Дээрээс нь бид нар дахиад яг органик бүх бүтээгдэхүүнийг НӨАТ-ынхаа хуульдаа хийгээд чөлөөлчих юм бол яг нөгөө дундын аж ахуйн нэгжүүд дээр ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмээд хэлчихье 3 номер. Татвартай холбоотой чухал



асуудал учраас Мөнхшүр. Нэмээд Ундрам гишүүн тайлбар хэлэх юм байна.

**Ч.Мөнхшүр:** НӨАТ дээр яг ингээд дэмжлэг гэхээсээ яг чөлөөлөх юм бол дундын яг ингээд борлуулагч аж ахуйн нэгжүүд, ресторанууд ч байдаг юм уу, нөгөө органик бүтээгдэхүүн худалдаж аваад цаашаагаа дахиад бүтээгдэхүүн үйлдвэрлээд борлуулж байгаа аж ахуйн нэгжүүд дээр НӨАТ-ынх нь нөгөө ард чөлөөлчихвөл 10 хувийнх нь дарамт нь шууд тэр дундын аж ахуйн нэгжүүд дээр очих эрсдэл байгаад байгаа учраас энэ нэг талаар ер нь дэмжлэг гэхээсээ илүү аягүй сөрөг үр дагавар гаргах гээд байгаа.

НӨАТ дээр нэг зүйл нь болохоор импортын бараа дээр органик бүтээгдэхүүнийг нөгөө чөлөөлье гэж орж ирсэн байгаа. Яг гааль дээр бараа ороод ирлээ гэхээр нөгөө беткусийн ангиллынхаа дагуу бараг 9 мянга хэдэн 100 ангиллын бараа орж ирдэг. Энэ бүх барааг органик төмс, органик биш төмс гэдэг нөгөө ангилал өөрөө гаргах аягүй хүндрэлтэй. Дээрээс нь гаалиар бараа орж ирлээ гэхэд бид нар нөгөө дотоодынхоо органик бүтээгдэхүүнийг гаалиар импортлох гээд байгаа биш гаднын аль нэг улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн наашаа органик бүтээгдэхүүн гээд орж ирэхээр нь бид нар шууд чөлөөлөх гээд байна шүү дээ. Тэгэхээр яг аль улсын яасныг бид нар органик бүтээгдэхүүн гэж үзээд гааль дээр тэрийг нь органик гэж үзээд тодорхойлохыг нөгөө чөлөөлөх вэ гэдэг ямар ч боломжгүй байгаад байгаа байхгүй юу. Яг гаалийн байцаагч тэрийг харснаа, хараад ингээд органик төмс байна, биш байна гэдгийг ялах ямар ч боломжгүй байгаад байгаа юм. Яг хэрэгжилт дээр бол.

Экспорт дээр оруулсан заалт нь бараг яг одоо байгаа заалтаа нөгөө дордуулахаар байсан нь экспортод гаргасан органик бүтээгдэхүүнийг нөгөө НӨАТ-өөс чөлөөлөхөөр заачихсан байсан.

Хэрвээ энэ чөлөөтийг нь ингээд хэрвээ хийчих юм бол нөгөө НӨАТ-ынхаа экспортод нөгөө органик бүтээгдэхүүн үйлдвэрлээд гаргаж байгаа аж ахуйн нэгж маань экспортод гаргачхаад нөгөө НӨАТ-ын буцаан олголт авдаг юм шүү дээ. Буцаан авалт хийдэг, тэр нөгөө буцаан авах НӨАТ байхад төлсөн татвар нь нөгөө буцаан авах ямар ч боломжгүй болчих юм. Тэгэхээр энэ өөрөө нөгөө нэг экспорт дээр оруулсан заалт нь бүр дордуулах заалт байгаад байгаа юм.

Тэгэхээр яг ийм ийм үндэслэлээр Сангийн яамнаас татварын энэ хуулиудыг оруулах шаардлагагүй. Одоо байгаа хөнгөлөлт, чөлөөлөлтийнхөө хүрээнд дэмжигдээд явах боломжтой гэж үзсэн байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Манай энэ Сангийн яамны 2 нөгөө органик, органик биш 2-ыг ерөөсөө ялгааг нь ойлгохгүй, ач холбогдлыг нь ойлгохгүй байна л даа. Жишээлбэл дотоодын сургууль, цэцэрлэгт органик төмс, хүнсний ногоо нийлүүлэх, органик биш баахан пестицид, гербицид, химийн хортой бодис хэрэглээд тарьчихсаныг нийлүүлэх 2-ыг 1 заалтаар адилхан гэж хэлж болохгүй. Худалдан авалтын тухай хуульд органик хүнсэнд илүү давуу эрх өгснөөр нөгөө органик биш тариаланчдыг биш яг органик гэж тийм ээ, баталгаажуулсан бүтээгдэхүүнийг нь тэр үр хүүхдийнхээ хоолонд хийвэл давуу эрх олгоё гэж би энэ дээр оруулаад байгаа юм.

2 дугаарт, энэ татварын хөнгөлөлт ч гэсэн органик биш хүнс тариалсан, органик тариалсан хоёуланд нь адилхан хөнгөлөлт биш, органикийг нь ялгаад илүү давуу эрх олгоё гэж органик хүнс үйлдвэрлэл рүү нь тэр хүмүүсийгээ шилжүүлэх гээд нэмэлт хөшүүрэг оруулах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр Монголд л тарьсан бол ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Баттөмөр гишүүн.

**Б.Баттөмөр:** Энэ Органик хүнсний тухай хуулийн батлуулах ажлын хэсгийн ахлагчаар надыг томилсон байгаа юм. Нэгэнт татварын олон асуудлууд энд байсан учраас Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг би оруулсан юм. Тэгээд өнөөдөр хэлэлцэж байгаа юм. Тэгээд үүнийг тал талаас нь хэдүүлээ ярьж байгаад нэгдсэн 1 ойлголт байхгүй, чуулган дээр оронгуут л сая тэр НӨАТ боломжгүй гээд л ингээд л ярьж байна шүү дээ, тийм ээ. Үүнийг нэг талд нь гаргаж шийдэх шаардлагатай гэж.

Энэ Органик хүнсний бүтээгдэхүүний тухай хуулийг үүнийг батална, батлахгүй гэсэн ийм маргаан байж болохгүй. Энэ үнэхээр Монгол Улсын энэ байдал төвөгтэй байгаа шүү дээ. Одоо хорт хавдар гэхэд л дэлхийд тэргүүлж байна. Хорт хавдрын нас баралтаар дэлхий тэргүүлж байгаа. Ялангуяа хоол боловсруулах ходоодных гэхэд л дэлхийд тэргүүлж байна шүү дээ. Тэгээд ийм хүнд үед энэ сая нэг хийсэн судалгаа байна л даа. 2023 онд энэ хүмүүсийн дунд хийсэн 1,3 сая хүний дунд хийсэн судалгаагаар 74,1 хувь нь өөрөөр хэлбэл 954 мянган хүн ходоодны замын ямар нэгэн тийм өвчтэй байна гэж гарч ирж байгаа юм. Тэгээд дээрээс нь дотоод шүүрэл болон тэр ходоодтой хамааралтай дахиад 13 гээд ингээд их өндөр тоо гарч байгаа байхгүй юу. Тэгэхээр Монголын энэ ходоодны хоол боловсруулах замын хорт хавдрын нэг хэсэг нь хүнтэй холбоотой байгаа юм. Тэгээд ийм судалгаа, аймшигтай судалгаа гарчихсан байгаа, 1 дүгээрт энэ.

2 дугаарт, дэлхий нийтээрээ энэ органик хүнсний төлөө явж байгаа. Дэлхийд миний олж мэдсэнээр 8 орчим хувь 8-10 орчим хувь нь органик хүнс байна гэж байгаа. Монголд 0,6, 5, 6 ч юм уу. 2030 он Алсын хараа-нд бид нар нэг 2030 он гэхэд нэг 5 хувьд хүргэнэ ээ гээд

ингээд оруулчихсан байж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар энэ органик хүнс дээр маш их анхаарч, арга хэмжээ авах ёстой. Аливаа асуудлыг дэмжихдээ юу гэхээр 1 дүгээрт, төр яаж дэмждэг вэ гэвэл татварын бодлогоор дэмжинэ. 2 дугаарт нь, урт хугацаатай бага хүүтэй зээлээр дэмжинэ. 3 дугаарт нь, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдаж авах ёстой. Энэ 3 дэмжлэг энэ Органик хууль дээр органик бүтээгдэхүүний хууль дээр зайлиггүй ийм шаардлага гарчихсан байгаа юм л даа. Тэгээд энэ органик хүнсийг би ингээд бодохдоо, энэ хувь хүмүүс үүнийг хийх боломжууд их гарч ирэх юм болов уу гэж бодоод байгаа юм л даа.

Бид нарын Монголын төрийн бодлого ямар цаашидаа яах вэ гэхээр энэ хувь хүмүүс хөдөлмөр эрхлэх ажлыг л их сайн дэмжиж өгөх ёстой юм байгаа юм шүү дээ. АНУ гэхэд л нийт татварын бүтцийн 54 хувь нь хувь хүний орлогын албан татвар. Гэтэл Монголд долоохон хувь байдаг байхгүй юу. Өөрөөр хэлбэл ажил хийхгүй байна гэсэн үг байхгүй юу. Тийм учраас үүнийг дэмжих ёстой.

Одоо ингээд татварын хөнгөлөлт гэхээр зэрэг л их л юм л явчихна гэж, одоо байхгүй татвар шүү дээ, энэ чинь, байхгүй татвар байхгүй юу. Бий болоод ирсэн үед нь татвар тогтоож болно. Тийм учраас энэ хуулийг цаашаа явуулах ёстой. Зүгээр ер нь хууль дотор засах, янзлах сая түрүүн тэр Ганбаатар гишүүний яриад байгаа засах юмнууд байна лээ. Үүнийг ажлын хэсэг үүнийг цаашидаа авч үзье гэж ингэж үзэж байгаа.

Ер нь органик хүнсийг дэмжих ёстой. Манай урд хөрш гээд тэгтэл 300 сая хүн дунд түвшиний амьдралтай, сайн амьдралтай болчихсон. Монголд үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүнийг хүнсний бүтээгдэхүүн худалдаж авъя гэж байгаа шүү дээ, тийм ээ. Тийм учраас экспортыг дэмжих ёстой. Тэр НӨАТ, НӨАТ-ыг нь экспортод гарч

байгаа бүтээгдэхүүн чинь НӨАТ нь тэг энэ тэр байдаг шүү дээ. Ийм учраас энэ дээр ямар нэгэн шалтаг энэ тэр хэрэггүй. Тийм учраас бүх талаар дэмжих ёстой, энэ хуулийг. Ингээд цаашаа гаргаад мөрдөөд ингээд явах нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Чойжилсүрэн гишүүн. Чойжилсүрэн гишүүн Алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалтыг явуулж эхлэх ёстой байгаа.

Санал хураалт 1 дүгээр асуудал. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл 2 зүйлтэй байгаа. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу?

Ийм зүйл л байгаад байгаа. Би нэг. Горимын санал Батжаргал гишүүн. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Үгүй ээ, тэр анхдагч хуулийг нь дэмжихээс арга байхгүй. Тэр органик бүтээгдэхүүний хуулийг. Тэгэхээр органик анхдагч бүтээгдэхүүн, түүн дээр суурилсан үйлдвэрийн бүтээгдэхүүн 2 нь бид дэмжих зааг ялгаагаа их тодорхой болгомоор байна л даа. Ямар арга ажиллагаат технологи удирдамжаар явж байж мал аж ахуйн бүтээгдэхүүн, газар тариалангийн бүтээгдэхүүн чинь органик байх юм бэ гэдэг юмаа тухайлсан хуулиуддаа шингээж өгөхгүй бол болохгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэр тариалангийн тухай хуульдаа ч гэдэг юм уу, тэр юмнууддаа ерөнхий анхдагч юмыг нь оруулж өгөх ёстой, тэр чинь.

Дараагийн асуудал хянан баталгаажуулалтынх нь тухай асуудал,

тэгээд мөшгөлтийн системийн тухай л асуудал байхгүй юу, үүний чинь. Тэгээд үүнийгээ тэр цаад хуульдаа ярих ёстой юм билээ гэж ингэж ойлгосон.

Ерөнхий дагаж орж ирсэн хуулиудынхаа асуудлыг Төсвийн байнгын хороон дээр төсөл өргөн баригчдын төлөөлөлтэй, холбогдох ажлын хэсгийнхэнтэй тэр санал солилцоод Хүн амын орлогын албан татварын тухай хууль нь, тэр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль нь, Худалдан авах ажиллагааны хуульд өөрчлөлт оруулж байгаа асуудлуудыг нь төсөл өргөн баригчид нь буцаах ёстой юм байна гэж ингэж ойлгоод байгаа. Тэгж ер нь би тогтлоо гэж ойлгосон. Учир юунд байна гэхээр зэрэг сая төсөв батлахдаа бид нар хүн амын орлогын албан татварынхаа асуудал дээр хөнгөлөлтийн нэлээн том юу нээгээд өгчихсөн. Түүнийг дагаад тэр буцаад явчих бололцоо байгаа юм байна. Нэмэгдсэн өртгийн албан татвар дээр үйлдвэрлэгчид нь биш тэр завсрын юунууд дээр юу үүсчих гээд байгаа учраас энийгээ эргэж харж зохицуулах нь зүйтэй юм байна гэж ойлгоод байгаа. Худалдан авах ажиллагааны хууль чинь 24 оны 01 сарын 01-нээс шинэ хууль мөрдөгдөнө. Гэтэл одоо энд явж байгаа хууль чинь болохоор зэрэг одоо мөрдөгдөж яваа хууль дээрээ яригдчихсан зүйл байна гэдэг асуудал байгаад байгаа. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварынх нь асуудлыг яах аргагүй өнөөдөр энд яриад, санал, дүгнэлтээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо руу хүргүүлэх ёстой юм байна гэж ингэж л ойлгосон шүү дээ.

Тийм учраас би даргыг юу гэх гээд байна гэхээр зэрэг тэр 3 хуулийг нь төсөл өргөн баригчдад нь буцаачхаад, наад хуулийнх нь дүгнэлтийг юу руугаа явуулахаар л ингээд л шийдчихвэл зөв юм байна л гэж хараад байна.

**Г.Тэмүүлэн:** Батжаргал гишүүний хэлсэн саналтай холбогдуулаад Ундрам гишүүн буюу хууль санаачлагч

өөрөө зарчмын санал гаргая гэж байна. Горимын санал. Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Батжаргал гишүүнтэй санал нэг байгаа. Хууль өргөн барьснаас хойш нөгөө 2024 оны төсвийг батлахдаа хүн амын орлогын албан татвартай холбоотой хөнгөлөлтүүд орчихсон. Хууль өргөн барьснаас хойш нөгөө худалдан авалтын хууль нь өөрчлөгдчихсөн байгаад байгаа. Тэгээд НӨАТ-ын хувьд нөгөө давхар нөгөө дэмжлэг биш тэрнээсээ харин сөрөг юм болчих гээд байгаа учраас энийгээ саяын энэ 3-ыг хууль санаачлагчийн зүгээс татчихъя гэж байгаа юм.

Энэ аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой асуудлыг харин та хэд маань хэлэлцээд дэмжээд өгнө үү гэсэн ийм хүсэлтэй.

**Г.Тэмүүлэн:** Тэгэхээр хууль санаачлагчийн зүгээс яг тодорхой санал өөрөө гаргалаа. Нөгөө энэ хуулийг боловсруулаад өргөн баригдах үед хууль, эрх зүйн зохицуулалтууд байгаагүй. 2024 оны төсөв дагасан хуулиудын хүрээнд Хувь хүний орлогын албан татвар болоод нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой зохицуулалтууд орсон байсан.

Дээрээс нь Тендерийн тухай хуульд оруулсан энэ өөрчлөлт өөрөө дараагийн бас батлагдсан хуулийн хүрээнд үйлчлэх хариу зохицуулалт байгаа учраас шинэчилсэн найруулгын хүрээнд зохицуулагдахааргүй байгаа учраас буцаан татъя гэсэн саналыг гаргаж байна.

Тэгээд хууль санаачлагч хэлэлцүүлгийн ямар ч үе шатад хуулийнхаа төслийг буцаан авах эрх нээлттэй. Энэ дагуу хуулийн төслийг буцаах саналыг гаргалаа.

Харин тэгэхээр Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудлыг хэлэлцэх шаардлагагүй болж байна. Нэмэгдсэн өртгийн албан

татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй болж байна. 3 дугаарх нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй болж байна.

Харин Аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой нэмэлт оруулах тухай хуулийн төсөл дээр хэлэлцээд явах юм байна. Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хууль 2 зүйлтэй. 2 зүйлтэй байгаа аж ахуйн нэгжийнх.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж асуулт асуух болон зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүд байна уу?

Энэ дээр би нэг зүйлийг асуух гээд байгаа юм. Энд нэг аж ахуйн нэгжийнх дээр нэг эшлэлийн буюу хууль зүйн талаасаа бичвэрийн нэг алдаа хийдэл байна гэж хараад байгаа. Тэгэхээр үүнийг ажлын хэсэг ажиллана, Улсын Их Хурал дээрээс. Үүнийг анхаарах ёстой. 6.1.1-д заасан гэж байгаад байгаа. 6.1.1 буюу энэ маань өөрөө. 6.1.1 нь өөрөө ингэж эшилж таарч байгаа. Энэ 6.1.1 маань, 6.1 маань органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрхтэй холбоотой асуудлууд байгаа. Тэгэхээр бид нар энэ эшлэлийг өөрөө зөв болгож, бичвэр юунд зүүн талаасаа 4.1.2 гээд органик бүтээгдэхүүн өөрөө хамрах гэдэг энэ зохицуулалтыг оруулах шаардлагатай байна гэсэн энэ санал байгаа. Ажлын хэсэг энэ дээр өөрөө анхаараад явах байх.

Яг 4.1.2 нь өөрөө буцаагаад 4.1.1 эшилчхэж байгаа. 4.1.1 дээрээ органик үйлдвэрлэл гэгчхэнгүүт нөгөөдөх нь бус үйлдвэрлэл гэж үйлдвэрлэл боловсруулалт, бэлтгэл, хадгалалт, тээвэрлэлт, худалдаа гээд бүх шатынхыг оруулж ирж таарч байгаа. Тэгэхээр бид нар энэ органик

үйлдвэрлэлээ шинээр ажлын хэсэг дээр анхаарч томъёолох шаардлагатай байна гэсэн энэ саналыг хэлэх байна.

Тэгээд үүнийг Төсвийн байнгын хороо Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд саналаа хүргүүлэх учиртай. Тэгээд энэ дагуу санал, дүгнэлт дээрээ саяын энэ асуудлуудыг тусгаад ингээд явъя гэсэн ийм саналтай байна. Тэгээд ажлын хэсэг Улсын Их Хурлаас байгуулчихсан ажлын хэсэг болоод Хөдөө аж ахуйн байнгын хороо энэ дээр онцгойлж анхаараад зохицуулалтуудыг хийгээд явах ёстой гэсэн саналтай байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу?

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбоотойгоор хугацааны асуудал байгаа. Хууль дээр өргөн баригдсан хуулийн төсөл дээр энэ хуулийг органик бүтээгдэхүүний хууль батлагдсан өдрөөс дагаж мөрдсүгэй гэсэн байгаад байгаа юм. Тэгэхээр үүнийг мэдээж цаг хугацааны хувьд 2024 оны төсвийн тухай хууль батлагдсан байгаад байгаа. Төсвийн тухай Татварын ерөнхий хуулийн 4.2-т зааснаар татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахад холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна гэж заасан байгаад байдаг. Тэгэхээр хуулийн үйлчлэлийг дараагийн он жил буюу 25 оны 01 сарын 01 гэдэг юм уу тодорхой дараагийн оны төсөвтэй уялдуулж, оруулж ирэх хуулийн хугацааг өөрчлөх ёстой гэсэн саналыг холбогдох Байнгын хороонд хүргүүлэх байна.

Ингээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд

нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж дууслаа.

Хууль санаачлагч бусад 3 хуулийн төслийг буцаан татах саналаа горимын саналыг гаргасан байгаа. Ингээд хуулийн төслүүдийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд миний бие бараг өөрөө шууд танилцуулчихъя даа. Тэгье.

Байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулна. Хуулийн төслүүдийг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэг болоод гишүүдэд баярлалаа.

14.57 цаг

Дараагийн асуудалдаа орцгооё. 2 дугаар асуудал.

**Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийн талаар гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж эхэлье.**

Танилцуулгыг Ерөнхий аудиторын орлогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч, Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Наранчимэг дарга танилцуулна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танхимд орж ирэхийг хүсье.

Наранчимэг дарга танилцуулгаа хийгээрэй. 2 номер. Наранчимэг даргын микрофоныг өгье. 2 номер микрофон нээлттэй байгаа.

**Ц.Наранчимэг:** Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, та бүхэнд хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж сэдэвт сэдвээр гүйцэтгэлийн аудит хийсэн тайлан, дүн дүгнэлтийг танилцуулъя.

Аудитыг бид Засгийн газрын шугамаар авч хэрэгжүүлсэн үр дүнтэй

ашиглаж байгаа хэсэг, зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалтад тавих хяналтын тогтолцоо, үр нөлөөтэй байгаа хэсэгт аудитын зорилгыг чиглүүлж, дүн дүгнэлт гаргахыг зорьсон. Аудитын хамрах хүрээнд бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт гадаад зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд, хэрэгжиж буй аж ахуйн нэгжүүд, төслийн удирдах хороо, төслийн нэгж, хэрэгжүүлэгч холбогдох байгууллагуудын 2016-2020 онд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа 9 төслийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг аудитад хамруулсан.

Аудитаар нийт Дэлхийн банкны 2, Азийн хөгжлийн банк, Японы ядуурлын бууруулах сангийн 4, НҮБ-ын хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн 1, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын 1 төслүүдийг аудитад хамрууллаа. Аудитаар Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгийн хэрэгжилт, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлгүй байгаа 12 төслийн мэдээллийг аудитад бүртгэлгүй байгааг хамруулсан байна. Аудитаар нийт 835,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулалтад 657,3 тэрбум төгрөгийг арилжааны банкаар дамжуулан олгохоор ишидвэрлэсэн зээлийн 178,6 тэрбум хөрөнгийг төсөл хариуцсан нэгжээр дамжин төслийн гүйцэтгэлд зарцуулагдсан байна.

Аудитад нийтдээ 2 бүлэгт дараах дүгнэлтийг өгсөн. Засгийн газрын шугамаар хөдөө аж ахуйн салбарт авсан зээлийн үр дүн, үр нөлөөг тооцох аргачлалгүйгээс төслийн бодит үр дүнг тооцоогүй байна гэж дүгнэсэн. Зээл, тусламжаар хэрэгжүүлж буй арга хэмжээ нь бүтээмжийг нэмэгдүүлэх, салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглүүлэх шаардлагатай байна гэсэн ийм 2 дүгнэлтийг сэдэв бүрд өгсөн.

Аудитаар нийт 56,8 тэрбум төгрөгийн 58 алдаа зөрчил илрүүлсэн. 52,5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 41 албан шаардлага, 4,2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулах 17 зөвлөмжийг аудитад хамрагдсан холбогдох газруудад хүргүүлж ажиллалаа.

Аудитаар илэрсэн зүйлдээ дүн дүгнэлтэд үндэслэн дараах дүгнэлтийг гаргасан. Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл удааширсан, зогссон, зориулалт нь өөрчлөгдсөн зэрэг зээлийн ашиглалтыг үр дүнгүй болгож байна.

Хөдөө аж ахуйн салбарт Засгийн газрын шугамаар авч хэрэгжүүлж буй зээлийн санхүүжилтийн 16,3 хувийг буцалтгүй тусламж болон бэлэн мөнгө, урамшуулалд, 18 хувийг зөвлөх үйлчилгээнд зарцуулснаар төслийн үндсэн зорилгын хамрах хүрээ хумигдсан байна. Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр зураг төсөл, ТЭЗҮ, тооцоо судалгаагүй, төлөвлөлтийн шалгуур хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь төслийн үр ашгийг бууруулж, төрөөс хөдөө аж ахуйн салбарт баримтлах бодлогын зорилт дэмжигдэхгүй байна.

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдэхгүй байгаа нь нэгдсэн шалгуур аргачлалыг батлаагүйтэй холбоотой байна. Хөдөө аж ахуйн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 14 төсөл, арга хэмжээний талаар Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан, цахим системд бүртгээгүйгээс Монгол Улсын төсвийн нэгдсэн байх зарчимтай нийцэхгүй байна.

Гадаадын зээл тусламжийн зориулалт, ашиглалт, хэрэгжих хугацаа,

үр дүн, холбогдох мэдээллийг төрийн захиргааны төв байгууллага цахим хуудсандаа ил тод бүрэн байршуулаагүй нь мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлээгүй байна. Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтад тавих хяналт тавьдаггүйгээс эзэнгүйдэж үрэгдэх, үнэгүйдэж үнэгүйдэх эрсдэл үүссэн байна.

Дамжуулан зээлдсэн зээлийн эргэн төлөлтийг Монголбанкнаас баталсан банкны үйл ажиллагаанд зохистой харьцааны шалгуур хангаагүй арилжааны банканд төвлөрүүлсэн нь зээлийг эргэн төлөх эх үүсвэр бүрдэхгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэж дараах зөвлөмжийг хүргүүлсэн.

Сангийн сайдад. Хөдөө аж ахуйн зээл, тусламж, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн дүн мэдээллийг Засгийн газрын өрийн мэдээллийн санд бүрэн оруулах,

Засгийн газрын шугамаар хөдөө аж ахуйн салбарт авсан зээлийн хэрэгжилтийн үр дүн, үр нөлөөг тооцох аргачлалыг баталж мөрдүүлэх,

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах эдгээр хөрөнгийг санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үнэлэх журмын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, чиглэлийн яаманд хариуцуулах,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад. Хөдөө аж ахуйн салбарт зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээллийг бүрдүүлж, зээл тусламж хариуцсан нэгжийн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох,

Засгийн газрын шугамаар авч ашиглаж буй гадаад зээлийн ашиглалтыг сайжруулж, гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, үр дүнг тооцох.

Төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг хүлээлцэх данс бүртгэлд тусгаж эзэмшигч, өмчлөгч ашиглалтыг тогтоож хариуцуулах,

Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлэх,

Экспортыг дэмжих төслийг хэрэгжүүлэх заавар арга зүйд өөрчлөлт оруулж сонгон шалгаруулалтад оролцох жишиг, дунд, бичил бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх,

Төслийн нэгжид төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан, зөвлөх, шинжээчийг хөлсөөр ажиллуулахдаа хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулан ажиллуулж, бүх татвар, шимтгэл, хураамжийг төлүүлэх,

Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, явцын хяналт, шинжилгээ, үнэлгээ болон хэрэгжиж дууссаны дараа эцсийн үнэлгээ хийж харьяалах төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнах,

Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний зориулалт, ашиглалт, хэрэгжих хугацаа, үр дүн, холбогдох мэдээллийг цахим хуудсанд бүрэн байршуулах,

Эрх бүхий гадаад улсын хуулийн этгээдийн боловсруулсан барилга байгууламжийн зураг төслийн баримт бичгийг Монгол Улсын эрх бүхий хуулийн этгээдтэй хамтран баталгаажуулсан байх,

Зураг төслийг баталгаажуулахад тавих шаардлагыг хангуулж, магадлалаа хийлгэж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжүүдийг хүргүүллээ. Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Наранчимэг даргад баярлалаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Сүх-Очир, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Зээлийн батлан даалт даалтын сангийн төсөл, бизнес хөгжлийн газрын дарга Тамир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Ганзориг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитын менежер Батчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Энх-Амгалан, Үндэсний Аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын аудитор Даишхонгор, ХАА, хөдөөгийн хөгжлийн нэгжийн төслийн хөгжил Нэгжийн зээлийн санхүүгийн шинжээч Мягмартүвшин, Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн зохицуулагч Ганбат гэсэн бүрэлдэхүүнтэй байна.

Тайлантай холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Гишүүдийн нэрсийг авъя. Ганбаатар гишүүнээр тасалъя. Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Ганцхан би л асуух юм байна. Арай ахиухан хугацаа өгнө биз дээ. Бэлгийн морины шүдийг үзэхгүй ээ гэж ярьдаг. Энэ бэлгийн морь биш шүү. Зээл юм байгаа юм. Бидний үр хүүхэд, хойч үе үүнийг төлнө. Дээр нь нэмээд гишүүд минь энэ аудитын материал энэ маш олон хүмүүсийн хүч хөдөлмөр, нойр хоолгүй л ажиллаж байж гаргасан материал. Үүнийг бүр а, б-гүй унш. Бидний нүд чих юм байгаа юм шүү.

Тэгээд миний тодруулж асуух хэдэн асуултууд байна. Асуулт маань ихэдчихээд байна. Хамгийн түрүүний асуулт. Хамгийн санаа зовмоор юм нь байна шүү дээ. Экспортыг дэмжих төслийн хуудас 27-оос эхэлчихье.

Экспортыг дэмжих төслийн гадаад болон дотоод зөвлөхийн зардал нь нийт зардлын 44,2 хувийг эзэлж байна гэж байна шүү. Ингэж болдог юм уу. Гаднынханд буцаад 44,2 хувийг нь өгсөн байна шүү дээ, энэ дээр. Би энэ доторх задаргааг нь уншаад яах вэ. Үүнийг хянах хэрэгтэй, хэн гэдэг зөвлөхөд яасан юм, ямар үр дүн гарсан юм. Малаа ядаж марксизмаар заалгахгүй юм сан л гэж өвгөд маань ярьдаг байсан. Одоо гадаадынхнаар заалгаж байгаа юм байна. ямар үр дүн гарсан юм? Энэ ноцтой мэдээлэл шүү.

2 дахь нь, 25 дугаар хуудсан дээр. Зээлийн хөрөнгийн тусламж хэлбэрээр тооцоо судалгаагүй, үр дүн нь тодорхой бус арга хэмжээнд зарцуулсан байна гэж. Би Хөдөө аж ахуйн яамны үйл ажиллагааг дэмждэг. Энэ дээр Сангийн яам голчилж хяналт тавьж, зохицуулалт хийх ёстой болов уу гэж би бодож байгаа шүү. Хариулт өгнө гэж би найдаж байна. Яагаад?

Дараагийн юм. Барилга угсралтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн. 1.92. Япон улсын Засгийн газраас ирсэн тусламжийг Мон 50 278 гэрээгээр 4



улирлын хүлэмж гээд энэ маш олон барилгууд байгаа. Зүгээр л барилга угсралтын төлөвлөлтийн шаардлага хангаагүй байхад дараагийн санхүүжилтээ хийж байна шүү дээ. Би эднүүсийг тодруулж асууж байгаа юм. Яагаад ийм байдалд орсон юм. Үүнийг яагаад засаагүй юм. Төслийн удирдах хороо байгуулаагүй, ерөөсөө юу ч байгуулаагүй. Зээлийн батлан даалтын саналыг дүрмээр төслийн үйл ажиллагааг санхүүжүүлж, хэрэгжүүлж байна. Ингэж хуульгүй доор хулгай, мэдлэггүй доор боол гэдэг юм шүү дээ. Энэ чинь хэдэн малчид л хохирно. Хөдөө аж ахуйнхан хохирно. Хамгийн аюултай нь. Үүнийг бидний хүүхдүүд хүүтэй төлнө. Ийм хүйтэн сэтгэлээр хандаж болох уу?

Хуудас 20. Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуйн төслийн хүрээнд зарим байриилд ажил зогссон. Хэрэгжилтийн хувь өмнөх оны үзүүлэлтээс буурсан, буурсан ч гэсэн шинэ байриилд өөр арга хэмжээ төлөвлөөд хэрэгжүүлээд явж байна. Ингэж болох уу? Миний асуулт их ойлгомжтой гэж би бодоод байна шүү.

Хуудас 16. Дамжуулан зээлийн гэрээ байгуулаагүй, шаардлага хангаагүй арилжааны банканд зээлийн эргэн төлөлтийн төвлөрүүлсэн байна. Шаардлага хангаагүй банканд байгаа. Би үүнийг 1.36-г Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалыг энэ баталсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах эдгээр хөрөнгөөр үнэлэх журмыг зөрчсөн. 20.3 энэ задаргааг нь цаг үрээд яах вэ дээ. Бусад гишүүд цагаа өгөх байх. Надад.

Хуудас 14. Энэ дэндүү ноцтой юм байна. Би 1.24, 1.25-ыг л унших гээд байгаа юм. Төлөвлөлтийн шалгуур бүрэн хангагдаагүйгээс ажлын явц, гүйцэтгэл зорилтот түвшинд хүрэхгүй байх шалтгаан болж байгаа. Давтагдаж, энэ хар даа, төлөвлөлттэй холбоотой алдаа зөрчлүүд нь удаа дараа давтагдаж байгаа нь төслийн явцыг удаашируулах, үр

дүнгүй болгох суурь шалтгаан болж, төслийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна. Зарим төсөл цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан удааширсан, санхүүжилтийг үр дүнгүй зарцуулсан, ажлын явц зогссон байгааг нь зарим гэдэг нь 7 төсөл байгаа шүү. Нийтдээ 9 төсөл, 11 төсөл байв уу даа. Би чинь энэ чинь. Юу яриад байгаагаа би нэг товчхон ярьчихъя.

213,7 сая доллар, 3,6 сая евро, 5 тэрбум иений тухай би ярьж байгаа шүү дээ. Энэ чинь мөн ч том мөнгө юм даа. 9 төсөл тэгээд 2 төсөл нь хэрэгжиж дуусчихсан байгаа. Хуудас 8 дээр байгаа мэдээллийг би ярьж байна шүү. Тэгэхээр би энэ дээр Сангийн яамныхан энэ гаднаас орж ирсэн зээл, тусламжийн төслүүдийг хянаж, шалгаж энэ дээр хууе хаая гэх ёстой болов уу гэж бодоод яах вэ, яг салбарын яам нь нөгөө жижиг, дунд үйлдвэрлэл тэр байгаа юу, тэр малчид тариаланчдаа явж байгаа байх. Сангийн сайдын ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Их тодорхой асуултууд асуулаа. Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Сангийн яам, Хөдөө аж ахуйн яам хэн, хэн хариулах вэ? Эхлээд гараа өргөцгөөгөөрэй. Эхлээд Хөдөө аж ахуйн яам, дараа нь Сангийн яам. Жамбалцэрэн дарга 3 номер дээр та оччих уу? Сангийн яамыг төлөөлж Сүх-Очир дарга байх уу, хэн байх вэ?

3 номер Хөдөө аж ахуйн яам Жамбалцэрэн дарга.

Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Асуулттай холбоотой нийтлэг ерөнхий асуултуудад хариулаад тэгээд манай төслийн зохицуулагч нар, төсөл хэрэгжүүлэх нэгжийнхэн маань ирсэн учраас дэлгэрэнгүй танд тодорхой хариултуудыг өгнө өө гэж ингэж бодож байна.

Аудитын хяналт шалгалтад хамрагдсан 9 төсөл, түүнтэй холбоотой 6 асуулт асуусан. Ерөнхий дүнгээр нь аваад үзэх юм бол Засгийн газраас өргөн барьсан Улсын Их Хурлаар соёрхон баталсан төсөл, хөтөлбөрүүд. Хэрэгжилтийг нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам хариуцаад явж байсан. 2019 оны 87 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн салбартай холбоотой ялангуяа энэ жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг дэмжихтэй холбоотой төсөл хөтөлбөрүүдийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжүүлж ирсэн. Энэ шилжүүлэх ажлын хүрээнд Япон улсын Засгийн газрын нэн хөнгөлөлттэй нөхцөлд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, Байгаль орчныг хамгаалах 2 үе шаттай зээл, Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй Хөдөө аж ахуй, Хөдөөгийн хөгжлийн нэмэлт санхүүжилтийн 2 төсөл, экспортыг дэмжих төслүүд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2019 оны 87 дугаар тогтоол, Засгийн газрын тогтоолоор Хөдөө аж ахуйн яаманд шилжиж ирсэн. Шилжиж ирснээс хойших мэдээллүүдийг бид нар дэлгэрэнгүйгээр өгч болж байна.

Өмнөх мэдээллүүдийг манай төслийн нэгжийнхэн маань дэлгэрэнгүй байдлаар өгөөрэй.

Зээлийн батлан даалтын сантай холбоотой тэр удирдах хороо байгуулж, ажиллаагүй гэдэгтэй холбоотой асуудлаар мөн Зээлийн батлан даалтын сан өөрөө бие даасан хуультай. Хуулийнхаа хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, өөрөө хуулийн этгээд ийм байгууллага байгаа. Тухайн байгууллага өөрөө энэ төслийг хэрэгжүүлэхэд зээлийн удирдах хороо байгуулах шаардлага байхгүй. Шууд арилжааны банкаар дамжаад зээлийн хөрөнгө нь арилжааны банкаар дамжаад батлан даалтад гараад явж байгаа. Ийм эх үүсвэртэй байгаа. Эх үүсвэрийн үр дүн, зарцуулалт нь тооцогдоод үр дүнтэй

ажиллаад явж байгаа. Энэ дээр таны тухайлан хэлсэн дүнгүүд ор мөргүй алга болчихсон зүйл биш юм гэдгийг хэлье.

Нөгөө талаар тэр Дэлхийн банкны санхүүжилттэй мал аж ахуй, эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн асуудлыг ярьж байх шиг байна. Тэр нь тухайн зээлийн тодорхой хөрөнгийг буцалтгүй тусламжаар бусад мал аж ахуйн салбарт зарцуулсан гэдэг асуудал дээр нийтдээ нэг 13 сая долларын асуудал байгаа. Энэ нь 20 оны өвөл, 21 оны хаврын байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө, энд зудтай холбоотой 5 сая доллар нь 6 аймгийн нийт сумд хамарсан тэжээлийн дэмжлэгт явсан. 8 сая доллар нь мөн Засгийн газрын шийдвэрээр нийт малчин өрхийн бэлэн мөнгөний орлогыг бууруулахгүй байх, энэ өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлыг давах, мөн ковидын нөхцөл байдалтай уялдуулаад малчин өрх болгонд мөнгөн дэмжлэг хэлбэрээр очсон. Ийм үзүүлэлттэй байгаа юм.

Мөн Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй 12 услалтын систем байгуулах нийтдээ 8 га-ийн услалтын системийн, 8000 га-ийн услалтын системийн төслийн асуудлыг ярьж байна. Төслийн асуудал үндсэндээ 4 жилийн хугацаанд хэрэгжих дэд бүтцийн төсөл байгаа. 12 услалтын системийг 4 жилийн хугацаанд ашиглалтад оруулах ёстой. Энэ хүрээндээ бид нар богино хугацаанд энэ төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд 10 услалтын системийн сонгон шалгаруулалтын худалдан авах ажиллагааг зохион байгуулаад ингээд зарлаад явсан. Харамсалтай нь энэ ковидын нөхцөл байдал, зураг төсвийн доголдолтой байдлаас зарим нэг услалтын системүүд дээр тодорхой саатлууд гарсан. Бусад энэ тохируулгын ажлуудыг хийгээд сайжруулалтыг хийгээд явж байгаа. 2 услалтын системийн байриил дээр гидрогеологийн судалгаа гэдэг юм уу, хөрсний шинжилгээгээр тухайн төслийг

хэрэгжүүлэх боломж тааруу, талбайн хэмжээг нь багасгах шаардлагатай гэсэн ийм мэргэжлийн байгууллагууд ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Жамбалцэрэн даргад минут нэмээд өгье, тайлбараа гүйцээгээд хэлье. 3 номер.

**Т.Жамбалцэрэн:** гэсэн үндэслэлээр байршлуудыг тодорхой байршлууд дээр аймаг орон нутгийн саналуудыг аваад байршлыг сольсон асуудал гарч байгаа. Энэ нь өөрөө Монгол Улсын Их Хурлаар соёрхон баталсан төслийн үндсэн баримт бичигт бичгийнх нь дагуу төслийн санхүүжүүлэгч байгууллагуудтай харилцан тохироцсоны үндсэн дээр мэргэжлийн байгууллагуудын санал, дүгнэлт дээр үндэслээд байршлыг шилжүүлэн зохион байгуулах ажлыг хийгдэж байгаа юм.

Экспортыг дэмжих төсөлтэй холбоотой 44,2 нь энэ зөвлөх үйлчилгээ байна гэдэг дээр манай Болорчулуун дарга дэлгэрэнгүй тайлбар мэдээллийг өгчих.

Үндсэн зээлийн хэлэлцээрийн маань бичиг баримтууд энэ чиглэл рүү түлхүү тусгагдсан учраас бид нар энэ соёрхон баталчихсан төслийн үндсэн бичиг баримтынхаа дагуу хэрэгжилтийг ингээд хангаад зохион байгуулаад явж байгаа юм гэдгийг хэлье. Болорчулуун дарга 44,2 хувьтай холбоотой мэдээллийг өгөөд, Зээлийн батлан даалтын сан тодорхой тэр мэдээллийг гүйцэтгэлийн мэдээллүүдийг өгчих. Болорчулуун дарга мөн 12 услалтын системийнхээ тайлбарыг өгчхөөрэй. Тэр 4 улирлын хүлэмжийн ажлууд хийгдээд явж байгаа. Төслийн захирал нь манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Есөн-Эрдэнэ байгаа. Есөн-Эрдэнэ дарга холбогдох яг технологи үйл

ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг нь өгчих.

**Г.Тэмүүлэн:** 3 номер Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун.

Ганбаатар гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. Тэгэхээр Дэлхийн банкны санхүүжилттэй нийт 20 сая долларын санхүүжилттэй экспортыг дэмжих төсөл байгаа. Энэ төслийн хүрээнд үндсэндээ анх байгуулсан гэрээний үндсэн дээр ер нь зөвлөх үйлчилгээний талын сургалт, судалгааны талын энэ зардлууд нэлээд тусгагдсан. Үндсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй ийм төсөл байгаа.

1 дүгээрт нь, экспортын даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх 1 дүгээр бүрэлдэхүүн хэсэг нь,

2 дугаар бүрэлдэхүүн хэсэг нь, экспортын чадавхыг бэхжүүлэх. Энэ дээр сургалт судалгаанууд нэлээн тавигдсан байдаг.

3 дугаарт нь, түншлэлийн хөтөлбөр гэсэн ийм үндсэн 3 бүрэлдэхүүнтэй 2016 оны 12 сарын 01-нээс энэ Сангийн яам дээр хэрэгжиж байсан ийм төсөл байгаа. 2020 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам руу шилжиж ирсэн. Өнөөдөр ингээд энэ хэрэгжих хугацаандаа хугацаагаа нэг удаа сунгасан байдаг. Ингээд 2023 оны 12 сарын 31-нээр энэ төсөл үндсэндээ дуусгавар болж байгаа ийм төсөл байгаа. Тэгээд энэ дээр тухайлах юм бол энэ олон улсын худалдааны байгууллагаар энэ үндэсний экспортын стратеги боловсруулах гээд анхны гэрээ хэлэлцээр дээр энэ бичиг баримтууд дээрээ эдгээрийг хийнэ ээ гээд тодорхой заачихсан учраас эндээс бид хазайж

болдоггүй. Энэ заасан тусгасан үйл ажиллагаанууддаа энэ зөвлөх үйлчилгээнийг авч хэрэгжүүлсэн учраас энэ дээр тухайлах юм бол энэ олон улсын худалдааны байгууллага нь Үндэсний экспорт стратеги байгуулахдаа маш олон зөвлөхүүдийг авч ажиллуулсан байгаа. Тэгээд энэ зөвлөхүүдийнх нь цалин, мөнгөнийх нь асуудал ингээж гарч ирж байгаа. Тийм учраас их өндөр харагдаад байгаа ийм асуудал байгаа.

Дээрээс нь мөн НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаар Юнито гэж байгууллагаар гэрээ байгуулж, 2 сая доллароор энэ зөвлөх үйлчилгээг авсан байдаг. Энэ зөвлөх үйлчилгээний хүрээнд сургалт, судалгаа, дээрээс нь манай Судалгаа хөгжлийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжид бид сүүлийн өөрчилж байж, сая 300 мянган долларын тоног төхөөрөмжийн шинэчлэлийг энэ зөвлөх үйлчилгээнээс нь зориулалтыг нь сольж байж ингээж хамгийн сүүлд авсан. Энэ худалдан авалтыг нь аваад ингээд дуусаж байгаа. Ийм хэлбэртэй энэ төсөл хэрэгжээд үндсэндээ ингээд дуусаж байгаа юм.

Зарим банкнуудад энэ эх үүсвэр байршуулсан төслүүд байгаа. Тухайлах юм бол Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил гэж төсөл 2016 оны 03 сарын 01-нээс энэ Сангийн яам дээр хэрэгжиж байсан төсөл. Ингээд 2017 оны 02 сарын 17-ны өдрийн 10/970 тоот албан бичгийн дагуу Сангийн яамны газрын даргын гарын үсэгтэйгээр энэ бол Чингис хаан банканд тодорхой хэмжээний энэ эх үүсвэрүүдийг байршуулсан ийм асуудал байгаа.

Нөгөөдөх нь нэмэлт санхүүжилтээрээ яг энэ өдрийн бичгээр Үндэсний хөрөнгө оруулалтын банканд тодорхой хэмжээний эх үүсвэрүүдийг байршуулсан ийм асуудал байдаг. Яг яаманд шилжиж ирсэн 19 оны 87 дугаар тогтоолын дагуу Сангийн яамнаас манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

яаманд шилжиж ирснээс хойш энэ төслүүд дээр нэмэлт хөрөнгийг эдгээр банкнуудад байршуулаагүй байгаа. Чингис Хаан банканд дээр шүүхийн шийдвэр гараад явж байгаа. Үндэсний хөрөнгө оруулалтын банк шүүхийн шатдаа ингээд энэ асуудалд хэлэлцэгдээд явж байгаа. Ийм асуудлууд байгаа.

Азийн хөгжлийн банкны усалгаатай хөдөө аж ахуй гэж 42 сая долларын төсөл түрүүн Төрийн нарийн бичгийн дарга хэлсэн. Нийтдээ 12 байришилд энэ услалтын систем 9000 га-ийн услалтын систем барих ийм том төсөл байгаа. Энэ бол он гараад энэ хавар эхний 4-5 услалтын систем нь тариалалтаа эхлүүлэхээр ингээд бэлтгэл ажлаа хангаад ажил нь амжилттай явж байгаа. Эхний ээлжид бид 10 тендер сонгон шалгаруулалтыг зарласан. Үүнээс 1 аж ахуйн нэгж нийт ажлын гүйцэтгэл 43 хувьтай яв ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүн нэмж тодруулъя.

**С.Ганбаатар:** Манай Хөдөө аж ахуйн яамныхан ер нь холбогдох улсууд маань ажлын төлөө л байгаа. Би түүн дээр санал нэгтэй байна. Тэгээд ажлыг нь улам үр дүнтэй болгох үүднээсээ сая ярьж байна шүү дээ. Тэгээд цаанаасаа ороод ирсэн юм. 100 сая төгрөг орж ирэхэд 44,7 буюу бараг 50 сая төгрөгийг нь буцаагаад гадаадын хүмүүст нь зөвлөх үйлчилгээ аваад өгчихдөг өө л гэж байна. Тэгээд л зөндөө яривал энэ би ингээд улаан эрээн болгочихсон байна. Дарга минь нэг ийм санал байж болох уу? Их Хурал энэ рамка бүтцийг нь бид сайн муу юм хийсэн байж болно. Газар дээр нь шалгаж, энэ гүйцэтгэлийн аудитын тайлангийн яг энэ олон зөрчлүүдийг газар дээр нь шалгаж, ажлын дүгнэлт гаргаж, Их Хуралд танилцуулмаар байна. Тэгээд миний санал бол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 112.4-д зааснаар Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно. Тэгээд

нэгдсэн хуралдаанд танилцуулах ажлын хэсэг байгуулаад, газар дээр нь үзэж хараад ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүнд минут нэмж өгье.

**С.Ганбаатар:** Сангийн яам байна уу, хүнс салбарын яамд байна уу, тэднүүстэй бид дүрэм журам, хууль тогтоомждоо арай чамбайруулах, арай тодорхой болох тийм саналууд байгаа гэж би үзэж байгаа учраас энэ дээр ажлын хэсэг, хөдөө аж ахуй, ер нь яг хөдөө амьдрал амьжиргаа хүндэрчхээд байна шүү дээ. Тэгээд энэ дээр гаднаас ирж байгаа энэ зээл, тусламжуудыг бодитой үр дүнтэй яг нөгөө малчин тариаланчдадаа нялзаадаг болохын тулд бид ажлын хэсэг байгуулаад, Их Хуралдаа танилцуулах нь зөв байх гэсэн байр суурийг илэрхийлж байна. Хүлээж авна уу.

**Г.Тэмүүлэн:** Ганбаатар гишүүн санал гаргаж байна. Дээрээс нь сая өмнөх асуусан асуултууд дээр Хөдөө аж ахуйн яам асуултуудад хариулаад өнгөрлөө. Сангийн яам, Сүх-Очир дарга. Та яг Сангийн яамнаас энэ өрийн бодлого, өрийн удирдлага, зээл тусламжийн асуудал хариуцсан. Түрүүний асуусан асуултад хариулаагүй байгаад байгаа. Сангийн сайдад нийтдээ 3 зөвлөмжийг аудитаас өгсөн байна. Хөдөө аж ахуйн сайдад 5, төслийн нэгжид 4 зөвлөмжийг өгсөн байгаа. Тэгэхээр аудитаас гаргасан энэ тайлан, дүгнэлт зөвлөмжийг бүрэн уншиж танилцах үүрэг Засгийн газарт буюу холбогдох яамнууд дээр байгаа. Ажил хариуцсан хүмүүст дээр байгаа. Энэ зөвлөмжийн мөрөөр тодорхой тайлан, биелэлтүүдийг гаргах, хэрэгжүүлэх арга хэмжээг авах үүрэг байгаад байгаа юм. Сангийн яам яг энэ аудитаас гаргасан дүгнэлттэй холбоотой. Та өөрөө ажил хариуцсан хүний хувьд энэ ТЭЗҮ-гүй, зураг төсөвгүй, үндэслэл тооцоо судалгаагүй ч гэдэг юм уу энэ асуудлуудыг ярьж байна.

Дээрээс нь гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж дууссан төслийн үр нөлөөний үнэлгээ хийгдэхгүй байгаа нь нэгдсэн шалгуур аргачлалыг батлаагүйтэй холбоотой гэдэг асуудлуудыг ярьж байна. Тэгэхээр яг энэ нийтлэг энэ асуудлууд бүх гадаад зээл, тусламж дээр ийм байгаад байна уу. Хөдөө аж ахуйн яам дээр онцгойлж ийм байгаад байна уу? Та нар хяналт хариуцлагаа тооцож чадахгүй байгаад байна уу? Мэдээллийн нэгдсэн сантай байх ёстой. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн нэгдсэн сан байх ёстой. Цахим системд бүртгээгүйгээс энэ хөдөө аж ахуйн салбарын 12 төсөл, арга хэмжээг гэж байгаа юм.

Монгол Улсын нэгдсэн төсөв, нэгдсэн байх суурь зарчимтай нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг аудит гаргасан байна. Гадаадын зээл, тусламжийн зориулалт, ашиглалт, хэрэгжих хугацаа, үр дүн, холбогдох мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд ил тод бүрэн байршуулаагүй л гэж байгаа юм. Энэ ил тод байдлын асуудал яаж байгаа бол? Яагаад энэ ил тод бус байна? Мэдээллийн ил тодыг байдлыг хангаж, олон нийтийн хяналт тавих боломжийг бүрдүүлээгүй байна. Гадаад зээл, тусламжаар бий болсон хөрөнгийн өмчлөл эзэмшил ашиглалтад хяналт тавьдаггүйгээс эзэнгүйдэж үрэгдэх үнэгүйдэх эрсдэл үүссэн байна. Ийм асуудлууд байна.

Тэгэхээр би хяналттай холбоотой гол үндсэн хяналт тавих энэ үүрэг хариуцлагууд мэдээллийн нэгдсэн бүртгэлийг бий болгох асуудлууд би Сангийн яам дээр ингэж харж байгаа. Сүх-Очир дарга 3 номер.

**Б.Сүх-Очир:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Ганбаатар гишүүн болон Тэмүүлэн даргын асуултад хариулъя. Түүнээс өмнө яг энэ гадаадын зээл, тусламжийн энэ ийм бодлого зохицуулалттай холбоотой бид нарын

нэг анхаарах ёстой нэг асуудал байгаа юм. Бид нар 2015 онд Өрийн удирдлагын тухай хуулийг гаргасан. Түүний өмнө бид нарын энэ яг гадаадын зээл авахдаа үүсгэж байхдаа мөрддөг байсан хууль маань Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль гэдэг хууль байсан. Тэгэхээр энд яригдаж байгаа ихэнх төслүүдийн асуудал анхандаа тэр Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн хүрээнд анхны үүсгэчихсэн зээлийн гэрээ, контрактын хүрээнд нэг бол бэлтгэл ажил нь тухайн үед явж байсан зээлүүд байдаг. Тухайн үеийн Гадаадын зээл, тусламжийн тухай хуулийн энэ Өрийн удирдлагын тухай хууль руу шилжих болсон үндсэн гол шалтгаан нь Өрийн удирдлагын тухай хууль дээр гадаадын зээл авахдаа ямар шаардлагыг хангах вэ, ямар нөхцөл үүссэн үед зээл авах вэ гэдэг агуулгыг тусгаж өгсөн байдаг. Гадаадын харин тэр хүчингүй болчихсон Гадаадын зээл, тусламжийн тухай хууль дээр авахдаа ямар нөхцөлийг л хангах вэ гэсэн агуулга байгаад байдаг. Тэр эдгээр зүйлүүд дээр Сангийн яам дүгнэлт хийгээд, 2015 онд Өрийн удирдлагын тухай хуулийг оруулсан байдаг.

Ер нь энэ хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн зээл, тусламжийн төслүүд дээр хийсэн аудитын тайлантай Сангийн яамны бүх газар, хэлтэс, холбогдох нэгжүүд танилцсан, тайлангийн дүгнэлт болон зөвлөмжтэй санал нийлж байгаа. Энэ дээр Өрийн удирдлагын тухай хууль дээр зээлийн нэгдсэн мэдээллийн сантай байна гээд байдаг. Одоо бол бид нарын хувьд тухайн байгууллагын төслийн хэрэгжилтийн явцад бүртгэдэг зээлийн мэдээллийн сан болон Өрийн эргэн төлөлтийн мэдээллийн сан гэсэн 2 үндсэн мэдээллийн сан байгаа. Цаашид үүнийг интеграц хийж нэгтгэх, 1 мэдээллийн сантай болгох ажил туршигдаад явж байгаа.

Мэдээллийн хувьд ер нь энэ эдгээр зөрчил маань зөвхөн хөдөө аж ахуйн салбарын зээлүүд дээр байна уу, нийтлэг

байна уу гэвэл ер нь нийтлэг иймэрхүү төрлийн зөрчил дутагдал ажиглагдаж байгаа. Манай Ганзориг дарга ирсэн байна. Илүү дэлгэрэнгүй хариулт хэлэх байх. Хэрэгжилтийн хэлтсийн дарга байгаа. Яагаад энэ зүйл маань нийтлэг ажиглагдаад байна вэ гэвэл 1 дүгээрт, тухайн 2021 он хүртэл явсан Сангийн газрын Сангийн яамны бүтэц дээр зээлийн контракт байгуулдаг нэгж болон хэрэгжилт 2 хамт явахаар хэрэгжилт маань ерөнхийдөө тэрэн дотор живээд алга болчихсон тийм бүтцийн агуулга байсныг 2011 оны Сангийн яамны бүтцийн өөрчлөлтөөр хэрэгжилт, ер нь төсөл хөтөлбөр гэдэг зүйл зээл байна уу, улсын төсвийн хөрөнгө оруулалт байна уу, нэг л зүйл. Ямар зээлээр санхүүжүүлж байгаа вэ гэдгээсээ ялгаатай гэдэг агуулгаар хэрэгжилтийг нь илүү анхаарсан байгаа. Тэр цагаас эхлээд хэрэгжилт дээр илүү яг улсын төсвийн хөрөнгө оруулалтыг яаж хянадаг вэ, яаж бүтцийнх нь хувьд явах вэ, ил тод байдлын нэгдсэн мэдээллүүд хийгдээд явсан байгаа.

Зээл авч байгаа зүйл бол жилээс жилд ер нь миний бодлоор сайжирч байгаа гэж үзэж байгаа. Хамгийн сүүлд гэхэд 2023 оны 7 сард орсон Өрийн удирдлагын тухай хууль болон Төсвийн тухай хуулийн өөрчлөлтөөр ил тод мэдээлж байж зээлээ авъя, нэгдсэн хэлэлцүүлэг хийе гэж зэрэг үндсэн шаардлагууд орсон байдаг. Тэгэхээр эдгээр зээлүүдийг хангаад явж байгаа, ерөнхийдөө. Аудитын зөвлөмжтэй санал нийлж байгаа.

**Г.Тэмүүлэн:** Ингэе. Сүх-Очир дарга аа. Та тайлбар хэлж болно. Тэгэхдээ би тайлбарыг хангалтгүй байна гэж харж байгаа. Тэгээд энэ Байнгын хорооны 4, 5 минутын хугацаанд ч гэсэн хангалттай тайлбарыг бид нар авч чадахгүй байна гэж харж байна. Аудит бол Төсвийн байнгын хорооноос гаргасан саналын дагуу бид нар энэ хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт үр өгөөжийг ер нь

нягталж нэг бүгдийг нь дүгнэж үзье гэсэн энэ саналаар аудитын жагсаалтад оруулж, ингээд аудит хийгдэж байгаа. Дүгнэлт ямар ч бай гарсан, аудит орсон.

Одоо хамгийн гол асуудал бол Сангийн яаманд 3 зөвлөмжийг хүргүүлсэн. Хөдөө аж ахуйн яаманд 5 зөвлөмжийг хүргүүлсэн. Төслийн нэгжид 4 зөвлөмжийг хүргүүлсэн байгаад байгаа юм. Тэгэхээр би яг ажил хариуцсан энэ холбогдох байгууллагууд, албан тушаалтнууд яг энэ аудитаас гаргасан албан шаардлага, акт төлбөрийн талаар ямар ажил арга хэмжээ авч хэрэгжүүлээд байгаа юм бэ? Хуулийнхаа дагуу 30 хоногийн хугацаанд та бүхэн хариуг нь хүргүүлсэн байх учиртай. Аудит 10 сарын 10-нд та бүхэнд энэ зөвлөмжүүдээ хүргүүлсэн байна. 30 хоног гэхээр 11 сарын 10 гэхэд бүх холбогдох энэ шаардлагуудын талаарх хариуг холбогдох байгууллагууд хүргүүлсэн байх учиртай байна.

Тэгэхээр нэн тэргүүнд 7 хоногийн дотор энэ холбогдох 3 байгууллага Үндэсний аудитын газар болоод, хэрэв хүргүүлээгүй бол, ер нь хүргүүлсэн байх учиртай. Хүргүүлээгүй бол хуулийн хариуцлага хүлээх бас асуудал байгаа. Тэгэхээр энэ холбогдох байгууллагууд Төсвийн байнгын хороо болоод Аудитын газарт бид нарт энэ тайлбаруудаа албан бичгээр нэмэлт мэдээллийг ирүүлэх шаардлагатай байна. Шаардлагатай байна.

Тэгэхээр дээрээс нь давхар энэ 7 хоногийн хугацаанд Үндэсний аудитын газартай нь холбогдох байгууллагууд уулзаж, энэ мэдээллүүд зөрөөтэй ч юм уу, буруу зөрөө байгаа бол нэгдсэн ойлголцолд хүрч, энэ үр дүнгийнх нь биелэлтийн талаар авч ирж байгаа арга хэмжээнийхээ талаарх мэдээллүүдээ ингээд өгөх хэрэгтэй байгаа. Төсвийн байнгын хороонд эдгээр мэдээллүүдээ ирүүлэх хэрэгтэй байгаад байна.

Ингээд 7 хоногийн дараа бид нар та бүхний мэдээллийг авсны дараа Байнгын хорооноос нэмэлт шаардлагатай мэдээллүүдийг авсны үндсэн дээр цаашид ямар арга хэмжээ авах талаарх тогтоол болоод холбогдох ажлын хэсэг байгуулах эсэх энэ талаарх шийдвэрийн төслийг оруулж ирнэ. Ийм саналыг гаргаж байна.

Ингээд Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн талаарх аудитын тайлантай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тайлантай холбогдуулаад үг хэлэх гишүүн байна уу? Би болохоор эхлээд 7 хоногийн дотор ингэж бодож байна. Ганбаатар гишүүн ээ, таны саналыг хүндэтгэж байна. 7 хоногийн дотор бүх энэ холбогдох байгууллагууд эхлээд аудитын зөвлөмж, албан акт, шаардлагын талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн юм бэ? Тайлбар нэмэлт мэдээллүүдээ өгөх гээд байгаа. Аудит бол хийдгээ хийгээд аудитынхаа тайлан, дүгнэлтийг гаргачихсан гэсэн үг. Тэгээд энэ холбогдох нэмэлт шаардлагатай мэдээллүүдийг нь авчхаад Байнгын хорооноос дараагийнхаа акц арга хэмжээндээ орно гэсэн ийм саналтай байна.

Тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Батжаргал гишүүн. Батжаргал гишүүн байгаа юм байна.

**Ж.Батжаргал:** Хөдөө аж ахуйн салбарт авч хэрэгжүүлсэн зээл, тусламжийн үр өгөөжийн асуудал, аудитаар гүйцэтгэлийн аудит хийгдсэн л дээ. Аудитын байгууллагын аудитын ажлын төлөвлөгөөнд Төсвийн байнгын хороо дээр санал гаргаж оруулсан юм. Угаасаа. Учир юунд байсан гэхээр зэрэг ер нь хөдөө аж ахуйн салбарт авч ашиглаад байгаа зээл, тусламжуудын онож байгаа эсэх, үр өгөөж, тэгээд аливаа төсөл хөтөлбөрөөс үлдэж байгаа

тэр сайн туршилага, арга барилуудыг ер нь үндэсний хэмжээнд нутагшуулах чиглэлээр бид ер нь юу хийгээд байгаа юм бэ? Тухайн хэрэгжүүлсэн төсөлтэйгөө цуг өнөө жаал хийгдсэн юмнууд алга болчихоод болж өгөхгүй байна л гэж ингэж л харж л үүнийг хийлгэсэн л дээ. Тэгээд мэдээж аудитын байгууллагаас тов тодорхой тайлан, дүгнэлт, зөвлөмжүүд гарсан байна. Хариуцсан салбарууд зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлсэн талаарх мэдээлэл юмнуудаа өгөх, мэдээж албан шаардлага актын барагдуулалт энэ тэр гээд ингээд тодорхой зүйлүүдийг нь хангаад 7 хоногийн дараа дахиж, Төсвийн байнгын хороонд мэдээлэх, тэгээд энэ дээрээс тулгуурлаж холбогдох арга хэмжээ авъя гэсэн энэ Төсвийн байнгын хорооны даргын саналыг би дэмжиж байна.

Одоо Засгийн газрын бүтцэд эдийн засгийн бодлого, төлөвлөлт, хөгжлийнхөө асуудлыг барьсан бүхэл бүтэн яамтай болчихсон. Тэгэхээр зэрэг ер нь аль салбарт, ямар тэргүүлэх чиглэл дээр энэ гаднын зээл, тусламжийн хөрөнгийг авч ашиглаж, үр өгөөж бий болгох юм гэдэг юмаа их тодорхой болгох ёстой, бид. Үүнийг бид онцгой бодох ёстой. Би тэгж бодоод байдаг. Дам дамаа энэ чинь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. Бүсүүдийн хөгжлийн асуудал нэлээн ирэх он жилүүдэд эрчимтэй яригдах нь байна. Нэг таталцалтай хөгжлөөс олон таталцалтай хөгжил рүү шилжих асуудлыг бараг улс төрийнх нь хүрээнд шийдэх асуудлыг Их Хурал яриад бүсчилсэн тойргийн тухай асуудал, төрийн эрх барих дээд байгууллагынхаа сонгуулийн үйл явцыг энэ хэлбэр лүүгээ шилжүүлж байна.

Тэгэхээр зэрэг хаана, хаана хөгжлийн төвүүд байх юм, тэнд юуг бид шийдсэн байх юм гэдэг асуудал хамгийн чухал байгаад байгаа юм. Тэгээд үүнийгээ 1 дүгээрт хийх ёстой гэж.

2 дугаарт, энэ нэг бүртгэл, мэдээлэл, үр өгөөж, гүйцэтгэлийн ажил, түүний үр дүнгийн асуудал эд нарыг олон жил яриад хэрэггүй дээ. Жижүүрийн асуудалтай байгаад хэрэггүй. Монгол ер нь зээл тусламж, энэ улс орны нэрийг бариад, магадгүй зарим нийгмийн бүлгүүдийн нэр барьж байгаад олон жил хэрэглэлээ шүү дээ. Одоо болих ёстой байхгүй юу. Одоо хөгжил рүүгээ авч хэрэглэмээр байна. Заавал тодорхой хэсгийнхээ нэрийг бариад тэгээд мөнгө гувчуулаад сууж байдаг тийм юм байж таарахгүй шүү дээ. Үүнийгээ бүрэн ангижрах ёстой, үүнээсээ. Энийгээ нэг бодож шийдмээр байна. Тийм учраас энэ гадаадын зээл, тусламжийн хөрөнгийн бүртгэл, мэдээлэл, гүйцэтгэл, үр өгөөж энэ бүх юмнуудыг хянаж чаддаг тэр дотоод эрх зүйн зохицуулалтаа бий болгоо. Энэ хуулиудад чинь олигтой юм байхгүй л байгаа учраас энэ нэг ийм юм чинь байнгын гарч ирээд л байна гэдэг л гэсэн ийм л санаа л байна шүү дээ. Тийм учраас энэ орчноо нэг бүрдүүлж янзалж авах нь зөв байх.

Дараагийн нэг зүйл мөнгөөр илэрхийлэгддэггүй үр өгөөжийн тухай асуудал байдаг. Одоо бид нар энэ өртгийн сүлжээний тухай ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** 1 минут нэмье. Батжаргал гишүүн.

**Ж.Батжаргал:** Маш олон төсөл хэрэгжүүлсэн байхгүй юу. Одоо Монголын энэ бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, өртгийн сүлжээний асуудал чинь бүр цэгцдээ ороод, дотоодынхоо асуудлыг шийдээд, экспортынх нь зам мөр бараг дэлхийн улс орнуудыг хангах түвшинд явсан байхгүй юу. Тийм хэмжээнд бид төсөл авсан. Тэгээд өнөөдөр шийдээж чадаагүй л байна шүү дээ. Тэр төслүүд мэдээж тов тодорхой, бидэнд сайн арга барил, сайн туршилага, зөвлөмжүүдийг үлдээсэн шүү дээ. Яагаад түүнийг бид нар тухайн чиглэл, бүтээгдэхүүн дээр нь гэдэг юм уу, уг



салбарт нь шингээгээд авч болохгүй байгаад байгаа юм бэ? Яг төслийн хөрөнгөтэй нь цуг дуусгаад, булшилчхаад байгаагаа ер нь юу гэж ойлгоцгоох юм? Тэгвэл ийм байдлаар юм авч ашиглаад байх хэрэг байгаа юм уу, ер нь. Тийм учраас энэ өртгийн гэдэг юм уу, мөнгөн дүнгийн илэрхийллээр хэмжигддэггүй тэр хөгжлийн шинэ загвар, арга барилуудыг нутагшуул ... /минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Гишүүд үг хэлж дууслаа.

Ингээд холбогдох байгууллагууд, зөвлөмж авсан албан тушаалтнууд биелэлтийг 7 хоногийн хугацаанд гаргаж ирүүлээрэй. 7 хоногийн дараа энэ асуудлуудыг дахиж эргэж хэлэлцэнэ.

Ингээд энэ асуудлыг хэлэлцэж дууслаа. Ажлын хэсэг болоод Аудитын үндэсний газарт баярлалаа.

15.41 цаг.

Дараагийн асуудалдаа орцгооё.

**Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-25 оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж эхэлье.**

Танилцуулгыг Сангийн сайд Болдын Жавхлан сайд танилцуулах байгаа. Сангийн сайд Жавхлан сайд хөдөө орон нутагт томилолттой яваа юм байна. Дэд сайд өвчтэй гэсэн байна. Төрийн нарийн нүүрсний сонсгол дээр байгаа юм байна, тийм ээ.

Тэгэхээр уг нь бид нар энэ хөдөө аж ахуйн гадаад зээл, тусламжийн үр нөлөө болоод үр ашгийн тайлан, энэ дээрээс нь Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилтийн тайлан эд нарыг уг нь цогцоор нь ингэж хамтад нь хэлэлцье гээд өнөөдрийн хуралдаанд оруулсан байсан. Тэгэхээр дараагийн

Байнгын хорооны хуралдаанд та бүхэн маань зөвлөмжийнхөө биелэлтүүдийг гаргаж ирүүлэх нь байна. Жавхлан сайдыг байлгаж энэ Засгийн газрын өрийн удирдлагын хэрэгжилтийн тайланг танилцуул гэдгийг Байнгын хорооноос үүрэг даалгавар болгож байна. Уг нь сайд байхгүй бол хөдөө орон нутагт томилолттой бол орлож байгаа сайд нь уг нь танилцуулах үүрэгтэй байгаад байгаа. Эсвэл Засгийн газрын өөр гишүүд танилцуулах үүрэгтэй байгаад байгаа шүү. Ингээд заавал ч үгүй дараагийн Байнгын хорооны хуралдаан дээр ондоо багтаж бид нар энэ асуудлыг хэлэлцэх хуулийн зохицуулалттай байгаа шүү.

Ингээд энэ асуудлыг дараагийн 7 хоног болтол хойшлууллаа.

Ингээд хэлэлцэх асуудал. 4 дэх асуудал байгаа юм байна. сүүлийнхээ асуудлыг орхих гэж байсан байна. 4 дүгээр асуудалдаа оръё.

**“Ажлын хэсэг байгуулах тухай” Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.**

Тэгээд Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар өнгөрсөн 7 хоногт Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 10 гишүүнээс 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, хэлэлцэх эсэхийг нь дэмжсэн байгаа. Үүнтэй холбогдуулаад Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг та бүхэнд оруулж байна.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Унишж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн

25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хорооноос тогтоох нь:

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 10 гишүүн 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл бус тодруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын гишүүн. Гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гэсэн байна.

2 дахь нь, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч Сандаг-Очирт зөвшөөрсүгэй гэсэн ийм Байнгын хорооны тогтоол байна.

Байнгын орон тогтоолтой холбогдуулаад асуулттай гишүүд байна уу? Алга байна.

Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Тэгвэл санал хураалтыг дэмжье гэдэг томъёоллоор, ажлын хэсэг байгуулах тухай тогтоолыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт.

Санал хураалт 63,6 хувиар дэмжигдлээ.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

Идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ